



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-48
1.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл	9-48

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
05 дугаар сарын 01-ний өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 72 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баасанжаргал, Б.Батбаатар, Д.Батлут, Б.Батцэцэг, Б.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, Т.Доржханд, Ц.Мөнхбат, Э.Одбаяр, Б.Пүрэвдорж, Л.Энхнасан;

Чөлөөтэй: Ч.Анар, Г.Дамдинням, Л.Оюун-Эрдэнэ, Ө.Шижир;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан, Р.Батболд, Х.Баттулга, Х.Болормаа, П.Наранбаяр, Б.Чойжилсүрэн;

Тасалсан: Л.Гантөмөр, Б.Жавхлан, Ч.Лодойсамбуу, Ц.Туваан, Ж.Энхбаяр;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан -20 минут, М.Бадамсүрэн -12 минут, Э.Бат-Амгалан -12 минут, П.Батчимэг -01 минут, Э.Болормаа -02 минут, Ш.Бямбасүрэн -19 минут, С.Ганбаатар -12 минут, Д.Ганбат -05 минут, Д.Ганмаа -04 минут, Ц.Даваасүрэн -12 минут, Б.Жаргалан -04 минут, Д.Жаргалсайхан -12 минут, З.Мэндсайхан -04 минут, М.Нарантуяа-Нара -12 минут, Г.Тэмүүлэн -01 минут, А.Ундраа -12 минут, Ч.Ундрэм -03 минут, Н.Учрал -17 минут, Г.Уянгахишиг -07 минут, Д.Цогтбаатар -1 цаг 36 минут, Ж.Чинбүрэн -01 минут, Д.Энхтүвшин -03 минут, Р.Эрдэнэбүрэн -40 минут.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Засгийн газраас 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав./10:02/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг, Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл ажлын 3 өдрийн завсарлага авах

тухай мэдэгдэж, уг асуудлуудаар Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ажлын 1 өдрийн завсарлага өгөв./10:09/

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан үг хэлэв.

Үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр товлосон Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг, Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг завсарлага авсан тул үдээс өмнөх хуралдаан 12 минут үргэлжилж, 10 цаг 12 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 00 минутад эхлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурлын гишүүдийн ажлын цаг ашиглалттай холбогдуулан үг хэлэв./14:03/

Нэг.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн комиссын гишүүн С.Дондов, Г.Нарантуяа, Ж.Хунан, Б.Энхболд, Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга Г.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Илтгэлийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанд идэвхтэй оролцож, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх боломж олгохын тулд асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүдийн нэр авах хугацааг сунгаж, 5 минут хүлээв./14:24-14:29/

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир, А.Ариунзаяа, Н.Алтаншагай, У.Отгонбаяр, Х.Булгантуяа, Ц.Идэрбат, Ц.Сандаг-Очир, О.Саранчулуун, Д.Энхтүвшин, Б.Мөнхсоёл нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн комиссын гишүүн С.Дондов, Г.Нарантуяа, Ж.Хунан, Б.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, О.Алтангэрэл, П.Сайнзориг, О.Батнайрамдал, С.Эрдэнэбат, Ж.Батжаргал, М.Нарантуяа-Нара нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.5, 22.3.6 дахь заалтын дагуу Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлтэй холбогдуулан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос Монгол Улсын Их Хурлаар шийдвэр гаргуулахаар ирүүлсэн дараах 6 бүлэг саналыг 1.Сонгох, сонгогдох эрхийн талаар Төрийн байгуулалтын байнгын хороо;

2.Хүний эрх хамгаалагчийг хамгаалах талаар Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хороо;

3.Хүний эрх ба цахим технологийн талаар Инновац, цахим бодлогын байнгын хороо;

4.Цахим орчинд үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллээс хамгаалах талаар Нийгмийн бодлогын, Инновац, цахим бодлогын болон Хууль зүйн байнгын хороо;

5.Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийг хамгаалах талаар Хууль зүйн болон Нийгмийн бодлогын байнгын хороо;

6.Шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилтийн талаар Хууль зүйн байнгын хороо тус тус хариуцаж холбогдох тогтоол, шийдвэрийг гаргах, дээрх Байнгын хороодоор хэлэлцсэн асуудлыг Хууль зүйн байнгын хороо мэргэжлийн Байнгын хорооны хувьд нэгтгэж, Улсын Их Хуралд танилцуулах чиглэл өгөв./16:23/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг хэлэлцэв.

Уг асуудлыг 16 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 2 цаг 36 минут үргэлжилж, 126 гишүүнээс 100 гишүүн хүрэлцэн ирж, 79.4 хувийн ирцтэйгээр 16 цаг 24 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая. 72 гишүүн ирцэд бүртгэгдэж, 57,1 хувьтай ирц бүрдсэн байна. 2025 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 1-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 3, 4 асуудал хэлэлцэнэ. 1 дүгээрт, Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. 2 дугаарт, Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Үдээс хойших хуралдаанаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг хэлэлцэнэ. 4 дүгээрт, Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан байгаа. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

1 дүгээрт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан “Засгийн газрын Өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд.

2.Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд тус тус хуваарилсан. Хэлэлцэх асуудалдаа оръё. Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Улсын Их Хурлын гишүүд, Цогтгэрэл дарга.

О.Цогтгэрэл: Өнөөдрийн, гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Өнөөдрийн пүрэв гаргийн үдээс өмнөх хуралдаанаар 3 асуудал хэлэлцэх юм байна.

Ардчилсан намын бүлэг хуралдаад, пүрэв гаргийн хуралдааны хэлэлцэх асуудлуудаас өнөөдөр байгаа чинь Зээлийн мэдээллийн сан, Жагсаал цуглааны эрх чөлөөний тухай, Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох тухай асуудлууд байгаа. Эдгээр асуудлуудаас, асуудлууд дээр тодорхой хэмжээний санал нэгдэх 1 дүгээрт нь шаардлага байгаа.

2 дугаарт нь зарчмын зүйл байгаа. Энэ нь өөрөө ер нь энэ Монгол Улсын эрх барих, төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурлын чадамжийн тухай, Улсын Их Хурлын зарим гишүүний бүрэн эрх ер нь хүчинтэй байгаа эсэх тухай ийм зарчмын асуудлуудаар Ардчилсан намын бүлэг бүлгийн удирдлагад завсарлага авахыг даалгасан. Саяын асуудлуудаар бид завсарлага авч, тодорхой хэмжээнд байр сууриа нэгтгэх ийм шаардлагууд хэрэгцээ шаардлагууд байгаа.

Тэр зарчмын асуудал гэдэг дээр өнгөрсөн 4 дүгээр сарын 25-ны Ерөнхий сайдын мэдээллийн цагаар Монгол Улсын Ерөнхий сайд Улсын Их Хурлын гишүүдийн асуултад хариулахдаа гаргаж байгаа хандлага, зүй бус байр сууриуд, саяын зарчмын гэдэг зүйлүүд. Энэ өөрөө нэг хувь хүмүүсийн хоорондын харилцааны асуудал төдий биш юм. Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулиар Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага. Монгол Улсын Засгийн газар Улсын Их Хурлаас томилогдож, хуулийн хэрэгжилтийг хангаж, хуулийн хэрэгжилтийг Улсын Их Хуралд тайлагнах үүрэгтэй ийм байгууллага. Энэ байгууллага Ерөнхий сайд болоод ер нь өнгөрсөн хугацаанд төрийн захиргааны албан хаагчдаас удаа дараа гарч байгаа хариуцлагагүй мэдээллүүд, дутуу дулимаг мэдээллүүд олон, олон зүйлүүд дээр Ардчилсан намын бүлгийн зүгээс тодорхой байр сууриудыг илэрхийлж, Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиудад тодорхой нэмэлт, өөрчлөлтийн саналуудыг бид өнгөрсөн сарын туршид боловсруулаад ажиллаж байсан.

Энэ өөрөө Улсын Их Хурлыг чадамжтай, Үндсэн хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд ард түмний төлөөлөл гэдэг энэ хүрээнд нь ажиллах энэ ажлуудыг бид бэлтгээд, Улсын Их Хурлын даргатай санал солилцоод, өргөн барих цаг бид хүлээгээд ингээд ажиллаж байгаа. Тэгээд энэ хугацаанд гарч байгаа удаа дараагийн үйлдлүүд, Ерөнхий сайдын тодорхой байр сууриуд үнэхээр энэ дээр Ардчилсан намын бүлэг хуралдаад энэ бол ёс зүйн асуудал төдий гэхэд хэцүү. Тэгээд Улсын Их Хурлын гишүүнээс болоод, Улсын Их Хурлаас тодорхой хэмжээнд уучлал гуйх ёстой гэдэг ийм байр суурийг гаргасан. Ийм учраас Ардчилсан намын бүлгийн зүгээс энэ үйлдлийг хийхийг шаардаж байгаа. Тэгээд Ардчилсан намын бүлгийн зүгээс эдгээр асуудал дээр 3 хоногийн, ажлын 3 хоногийн завсарлага өгнө үү гэж Улсын Их Хурлын даргаас хүсэж байна.

Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаанд байгаа хүний эрхийн, хүний эрх, эрх чөлөөний илтгэлийг энэ цаг үеийн чухал асуудал учраас үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаанаар хүний эрхийн илтгэлээ сонсоод, санал, дүгнэлтээ гаргаад явах нь зүйтэй байх гэдэг ийм байр суурьтай байгаагаа илэрхийлье.

Д.Амарбаясгалан: Цогтгэрэл даргаа Улсын Их Хурлын тухай хуулиар 30.1.5 дээр нэгдсэн болон Байнгын, дэд хорооны хуралдааны үед тухайн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан завсарлага авна гэсэн хуулийн заалт байж байгаа. Тэгэхээр таны ярьж байгаа асуудал чинь яг хэлэлцэж байгаа асуудалтай холбогдож байгаа зүйл алга байна шүү дээ. Тийм. Тэгэхээр яг одоо та дахин

тодруулж хэлээч. Яг хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж завсарлага өгөх боломжтой. Тэгээд 1 дэх асуудал Зээлийн мэдээллийн сангийн тухай хуулийн асуудал байна. Завсарлагыг зөвхөн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж байгаа учраас явна. 1 дэх асуудал нь Зээлийн мэдээллийн сан, 2 дахь асуудал нь Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай, 3 дахь асуудал нь Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг хэлэлцэнэ, 4 дэх асуудал нь Эрүүл мэндийн даатгалын сангийн, даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэхээр байгаа. Та нэг тодруулж хэлье. Цогтгэрэл даргын микрофоныг өгье.

О.Цогтгэрэл: Сая би эхэнд нь уг нь хэлсэн дээ. Зээлийн мэдээллийн сангийн асуудал, 2 дугаарт нь Жагсаал цуглааны хийх эрх чөлөөний байдлын тухай хуулийн асуудал, 3 дугаарт нь Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох гэдэг эдгээр 3 асуудлууд, шаардлагатай бол хууль тус бүр дээр нь завсарлагыг хэлье. Эдгээр 3 асуудлаар Ардчилсан намын бүлэг байр сууриа нэгтгэх шаардлага байгаа. 4 дүгээр асуудал Хүний эрх, эрх чөлөөний талаарх 24 дүгээр илтгэлийг үдээс хойших хуралдаанд байх шиг байсан. Энэ нь цаг хугацаандаа хэлэлцэгдээд явах нь зүйтэй байх гэдэг байр суурьтай байгаа юм.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр завсарлагыг 3 хоногийн хугацаатай гэхээр даваа гарагт Улсын Их Хурлын чуулган хуралдах шаардлагатай болно гэсэн үг шүү дээ. Яах вэ мэдээж улс төрийн намын бүлэг хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж 5 хүртэл хоногийн хугацаатай завсарлага авах эрх байгаа. Тэгэхээр төрийн ажил тасралтгүй явах зарчмаа ч бодъё. Зээлийн мэдээллийн сангийн тухай хуулийн анхны хэлэлцүүлэг, Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулган дээр бүрэн хийсэн. Гишүүд асуулт асуусан, хариулт авсан, гишүүд бас үгээ хэлсэн байгаа. Өнөөдөр зөвхөн санал хураалт явагдах ийм нөхцөл байдалтай.

Тэгэхээр эдгээр асуудал дээр Ардчилсан бүлэг хуралдаж, саналаа нэгтгэх шаардлагатай гэж үзэж байгаа учраас Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэх, анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулах асуудлыг 1 өдрийн завсарлага өгье. 1 өдрийн завсарлага, маргааш үргэлжлүүлэн хэлэлцэнэ. 2 дахь асуудал Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг бас бүрэн хийсэн байгаа. Асуултаа асуусан, хариулт авсан, үгээ хэлсэн, санал хураалт явагдахаар байгаа. Тэгэхээр 1 өдрийн завсарлага өгье. 4 дэх асуудал буюу Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал орж ирнэ. Энэ асуудлыг бас 1 өдрийн завсарлага өгье. Үдээс хойших хуралдаан Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг хэлэлцэж үргэлжилнэ. 14 цагт хуралдана.

Энэ асуудалтай холбогдуулаад гишүүд нийтээрээ хэд хэдэн зүйл дээр анхаарах шаардлага байгаа. Мэдээж Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүд бие биедээ харилцан хүндэтгэлтэй хандаж байх учиртай. Бид төрийн ажлыг тасалдуулахгүй явуулах үүрэг хүлээсэн. Улсын Их Хурал дээр мэтгэлцэх, маргалдах олон зүйл урьд өмнө нь ч гарч байсан, цаашдаа ч гарч явна. Гэхдээ

харилцан хүндэтгэлтэй байж, төрийн ажлыг явуулах зарчим дээр суурилж ажиллах ёстой.

Мэдээж Улсын Их Хурлын гишүүдээс үе, үе гомдлууд ирдэг. Байнгын хорооны хурал дээр, чуулганы нэгдсэн хуралдаан дээр асууж байгаа асуултад хариулт өгч байгаа албан тушаалтан оновчтой хариулт өгөхгүй байна, тойруулж байна, буруу зөрүү хариулж байна. Зарим тохиолдолд асуусан асуултад эргүүлж хариулж байгаа байдал нь ихэрхсэн хэлбэрээр хариулж байгаа нөхцөл байна гээд Байнгын хорооны хуралдаанаас өгсүүлээд гишүүдээс гомдол санал гарч байгаа. Улсын Их Хурлын гишүүд асууж байгаа асуулт нь илүү мэргэжлийн байдаг, оновчтой байдаг, зарчимтай байдаг, хариулж байгаа, хариулт өгч байгаа албан тушаалтан ч гэсэн илүү мэргэжлийн байж, оновчтой хариулт өгдөг байх нь энэ Улсын Их Хурлын үндсэн үүрэг.

Улсын Их Хурал бол ард түмнээс сонгогдсон, бага ард түмний үүргийг гүйцэтгэж, төлөөлж байгаа институт. Тэр утгаараа бүх асуудал дээр хариуцлагатай хандах ёстой. Аливаа байдлаар асуудалд субъектив хандахгүй байхыг гишүүд анхааралдаа авч ажиллах нь зүйтэй юм. Тэгээд энэ мэтчилэн асуудлаас үүдэлтэйгээр Улсын Их Хурлын хэлэлцэх асуудал дээр саад тотгор учирдаг, төрийн ажил явахад бэрхшээл тулгардаг байж ерөөсөө болохгүй. Цаашдаа ийм зүйлийг хүлээж авах боломжгүй.

Улсын Их Хурлын гишүүд хуулиар хүлээсэн эрх, үүргийн асуудал байдаг. Чуулганы танхимд хэлсэн үгэндээ хариуцлага хүлээхгүй. Хүлээхгүй гэдгийг далимдуулж Улсын Их Хурлын гишүүд бие биеийнхээ нэр төрд халдах бол нөхцөл, боломж байж болохгүй гэдгийг анхаарч ажиллах хэрэгтэй. Нөгөө талаасаа Улсын Их Хурлын гишүүд маань хэт их эмзэг байгаад хэрэггүй. Энэ улс төрийн ажил бол олон янзын хэлбэрээр явагдаж байдаг. Дотор талдаа ч тэр, гадна талдаа ч тэр гүтгэх, доромжлуулах гээд олон нөхцөл байдал дундуур улс төрч хүн туулаад явж байдаг. Иймэрхүү нөхцөлүүдийг давж чадсан хүмүүс нь улс төрч болж явдаг, давж чадаагүй хүн нь тэгээд байрандаа очоод явдаг гэх юм уу. Олон нийтээс ирж байгаа санал шүүмжлэл, олон гүтгэлэг, олон зүйлийг тэсэж, тэвчиж гарч чаддаг л байх нь улс төрч хүнд байх ёстой зан гэдгийг харах нь зүйтэй гэж бодож байна.

10.12 цаг

Үдээс өмнөх чуулганыг түр засварлуулъя. 14 цагаас хурал үргэлжилнэ.

2025 оны 05 дугаар сарын 01, Пүрэв гараг,
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 00 минут.

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд танхимдаа орж ирье. 2025 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан эхэлж байна. Хэлэлцэх асуудалдаа орёе.

Нэг.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг хэлэлцэхээр байгаа. Улсын Их Хурлын гишүүдийг танхимдаа орж ирэхийг урья.

Улсын Их Хурлын чуулган өглөө 10 цагт, үдээс хойших хуралдаан зарласан цагтаа яг эхэлж байгаа. Тэгэхээр гишүүд завсарласан, үдийн цайндаа орсон, одоо чуулганы хуралдаан цагтаа эхлэхэд танхимдаа ирж, сууж оролцож байх шаардлагатай. Илтгэлийг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Дугарын Сүнжид танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Сүнжид: Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд э,

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1.12, 9 дүгээр зүйлийн 9.1, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.5-д заасан чиг үүргийн дагуу комиссоос Монгол Улс дахь хүний эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр улсын Их Хуралд хүргүүлээд байна. Энэ удаагийн илтгэлийг комиссоос 2024 онд гүйцэтгэсэн судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ, комисст ирсэн гомдол, мэдээлэл, комиссын гишүүний санаачилгаар хийсэн хяналт шалгалтын үр дүн, мөн төр, иргэн, иргэний нийгэм, олон улсын байгууллагуудын албан ёсны тайлан мэдээлэл, бусад эх сурвалжид үндэслэн 6 бүлгийн хүрээнд боловсруулж, Монгол Улсын Их Хурлаар шийдвэр гаргуулахаар 45 саналын хамт тоймлон танилцуулж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийн зарим асуудал сэдэв. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, Монгол Улсын Үндсэн хуульд хүүхдийн ашиг сонирхлыг түр хамгаалахаар баталгаажуулж, холбогдох бусад хууль тогтоомжид хүүхдийн халдашгүй чөлөөтэй байх эрх, холбогдох төрийн байгууллагын үүргийг хуульчилсан хэдий ч хүүхэд бэлгийн хүчирхийллийн хохирогч болох тохиолдол буурахгүй байгаа учир бодитойгоор зарим арга хэмжээг хойшлуулшгүйгээр авах нэн чухал шаардлага тулгамдаад байна гэж үзлээ.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн орныхоо хувьд 2010 оноос НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг, хүний эрхийн гэрээний хороодод Монгол Улсын хүний эрхийн нөхцөл байдлын талаарх тайлан, нэгдэн орж, соёрхон баталсан Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн тайланг тогтмол хэлэлцүүлж ирсэн бөгөөд НҮБ-ын механизмуудаас хүүхдийн эрх, түүн дотроо нөхөн үржихүйн хүчирхийллээс ангид байх эрхэд онцгой ач холбогдол өгч, нэн тэргүүнд анхаарахыг зөвлөж байна. Комиссоос эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрх хамгааллын байдалд дүн шинжилгээ хийж, хүүхдийн эрхийн асуудлаар мэргэшсэн судлаач, шинжээч, энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нарт тусламж үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалт, ярилцлага, хууль хяналтын болоод хүүхдийн эрх хамгааллын чиглэлээр ажиллаж буй төрийн байгууллагын тоон мэдээлэл, хяналт шалгаж, дүн шинжилгээнд үндэслэн бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрх хамгааллын талаар эн тэргүүнд анхаарах асуудлыг дүгнэж, цаашид давах арга хэмжээний 9 саналыг илтгэлийн 5 дугаар бүлэгт дэвшүүллээ.

Сонгох, сонгогдох эрх 2024 оны сонгуулийн үйл ажиллагаа. Төрийн бүх эрх нь ард түмний мэдэлд байх Үндсэн хуульт ардчиллын төрийн гол шинж юм. Монгол Улсад хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм байгуулах 1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлалд тулгуурлан Монгол Улсын Үндсэн хуулийн 3.1 дүгээр заалтад Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна гэдгийг баталгаажуулсан билээ. Монгол Улсад 2024 оны 6 дугаар сард Монгол Улсын Их Хурлын, 2024 оны 10 дугаар сард аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Иргэдийн Хурлын 9 дэх удаагийн ээлжит сонгуульд зохион зохион байгуулагдлаа. 92 оноос хойш Монгол Улсын Их Хурал 76 гишүүнтэй байгуулагдаж байсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу 2024 оноос 126 гишүүдээс бүрдэх болсон бөгөөд 78 гишүүн олныг төлөөлөх, 48 гишүүн хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгох холимог сонгуулийн тогтолцоог анх удаа хэрэгжүүлсэн онцлогтой сонгууль байлаа. Комиссоор хуулиар, комисс хуулиар хүлээсэн чиг үүрэг бүрэн эрхийнхээ хүрээнд 2024 оны Монгол Улсын Их Хурал болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулиар сонгуулийн эрх бүхий иргэд бүх нийтээрээ, шууд, тэгш эрхийн үндсэн дээр саналаа чөлөөтэй, нууцаар гаргах үндсэн зарчмыг хэрэгжүүлсэн байдалд дүн шинжилгээ хийж, шийдвэрлэх асуудлыг тодорхойлж, цаашид давах арга хэмжээний талаарх 7 саналыг энэхүү бүлэгт тусгалаа.

Хүний эрх хамгаалагч болох өмгөөлөгч, сэтгүүлчийн өнөөгийн нөхцөл байдал. Монгол Улсад хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны баталгаа, хамгаалалтыг 2021 онд хуулиар тодорхойлж, тэдний эрх, үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих, хамгаалах механизмыг шинээр байгуулсан. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1 дэх хэсэгт заасны дагуу комиссын дэргэд хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус хороо ажиллаж, уг хуулийн хэрэгжилт болон хүний эрх хамгаалагчийн нөхцөл байдалд дүн шинжилгээ, судалгаа хийж, Монгол Улс дахь хүний эрх чөлөөний байдлын талаарх илтгэлд тусгах чиг үүргийг 3 дахь жилдээ хэрэгжүүлж байна.

Хүний эрх, эрх чөлөө, нийтийн эрх ашгийг хамгаалахад үйлчлүүлэгчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, хууль зүйн туслалцаа үзүүлдэг өмгөөлөгчид, нийгмийн шударга ёсыг шаардан үзэл бодлоо илэрхийлж, олон нийтийн мэдэх эрхийг хангахын төлөө ажилладаг сэтгүүлч нь өөрийн, бусдын нийтийн эрх ашгийг хамгаалсан үйлдлийн улмаас заналхийлэл, дарамт шахалт, халдлагад өртөх, ял шийтгүүлэх эрсдэлтэй ажил үүрэг эрхэлж байна. Иймд өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад нь удирдлага болгодог Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, сэтгүүлчдийн хувьд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ тулгамдсан болохыг энэ сэдвийн хүрээнд дахин сануулж байна. Комиссоос 24 онд хийсэн хүний эрх хамгаалагч, өмгөөлөгч, сэтгүүлчийн өнөөгийн нөхцөл байдал судалгааны дүнд тулгуурлан аюулгүй байдал, хуулийн хүрээнд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах боломж, баталгааг нэмэгдүүлэхэд чиглэсэн 7 саналыг дэвшүүлээ.

Хүний эрх ба цахим технологи. Цахим технологийн хөгжил харилцаа холбооны хувьсгал хийж, мэдлэгийг ардчилж, бүтээмжийг дээшлүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулах төдийгүй хүн төрөлхтний энх тогтвортой орших найдвар шийдэл болж байна. Гэвч мэдээлэл өгөгдлийг их хэмжээгээр цуглуулж

боловсруулах үндсэн горимоор ажилладаг цахим технологиуд хүний эрх, эрх чөлөөг ноцтой зөрчих эрсдэлийг дагуулдаг. Орчин үеийн нийгэмд хүний хувийн мэдээлэл бүртгэгдэхгүй орон зай үгүй болжээ. Ухаалаг тодотголтой гар утас, таблет, цаг, компьютер, видео тоглоом, олон нийтийн сүлжээ зэрэг, тэдгээрт суулгасан программ хангамжууд, орон байрны аюулгүйн систем, тасалгааны гэрэлтүүлэг, телевиз, чанга яригч, угаалгын машин гэх мэт ахуйн эд зүйлс, хяналтын камерууд, нийтийн интернэт, автомашиныг дугаараар хянах систем, зогсоолын төлбөр төлөх цэг зэрэг нийтийн орон зайд суурилуулсан цахим төхөөрөмжүүд ч хүний амьдралын талаарх их хэмжээний мэдээллийг тасралтгүй бүрэн цуглуулж байна.

Хувийн мэдээлэл, хувийн нууц, хувийн орон зайг чанд хамгаалах нь хүний халдашгүй байх, эрх чөлөөтэй орших үндэс билээ. Дарамт хавчлагаас эмээх айдас хүмүүсийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрмэлзлийг бөхөөж, төрийн үйл хэрэгт оролцох хэлбэр төдий болгож, улмаар ардчилал хэврэгшихэд хүрдэг. Тиймээс хиймэл оюун ухаан, цахим технологийн тооцооллын алдаа хүмүүсийг ялгаварлан гадуурхагдах, хэлмэгдэх нөхцөлийг үүсгэж, алгоритмын ил тод бус байдал нь түүнд хяналт тавих, шүүхэд хандаж эрхээ сэргээх боломжийг хязгаарлаж байна. Төрийн үйлчилгээг цахимаар хүргэхэд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг зарим бүлгийн иргэдэд бэрхшээл тулгардаг болохыг харгалзаж, цахим хуваагдлын эсрэг арга хэмжээ авах нь чухал бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжийг сайжруулах, бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг уялдуулах, ялангуяа хүний эрхэд нөлөөлөх эрсдэлийг тооцож, нэн шаардлагатай хэрэгжүүлэх арга хэмжээ, арга хэмжээг дүгнэж, 8 саналыг хүний эрх ба цахим технологи сэдвээр дэвшүүллээ.

Цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийллийн өнөөгийн байдал. Дэлхий нийтээр технологийн хурдацтай хөгжил нь жендерт суурилсан хүчирхийлэл үйлдэх шинэ сувгуудыг бий болгож, хүчирхийллийн арга хэлбэр өөрчлөгдөж байна. Жендерт суурилсан хүчирхийлэл нь цахим болон бодит орчинд аль алинд нь нөлөөлж буй асуудалд онцгой анхаарал хандуулж, илүү үр дүнтэй, цогц арга хэмжээ авах хууль тогтоомжийг боловсронгуй болгохыг НҮБ-ын хүний эрхийн механизмууд зөвлөж байна. НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаарх тусгай илтгэгч 2021 онд Монгол Улсад ажиллаад, жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх хариу арга хэмжээ сайжруулах, мөн цахим орчин дахь хүчирхийлэлтэй үр нөлөөтэй тэмцэх хууль тогтоомжийг боловсронгуй болгохыг зөвлөсөн байна. Цахим технологи ашиглан үйлдэгдэж жендерт суурилсан хүчирхийлэл нь технологи ашигладаг, цахим орчинд идэвхтэй байдаг хэн ч өртөх эрсдэлтэй бөгөөд дэлхий нийтийн судалгааг харахад охид, эмэгтэйчүүд, залуучууд ихээр өртөж байгаа учраас Монгол Улс ч гэсэн энэ төрлийн хүчирхийлэлд анхаарал хандуулах шаардлагатай байна. Комиссоос Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 15.1.4б-д заасан чиг үүргийнхээ хүрээнд технологийн тусламжтай үйлддэг жендерт суурилсан хүчирхийллийн өнөөгийн байдал хэмээх үнэлгээний тайланд тулгуурлан энэ хүрээний асуудал жендерт суурилсан хүчирхийллийн нөхцөл байдалд анхаарах асуудал, цаашид авах арга хэмжээний талаарх 4 саналыг дэвшүүллээ.

Шударгаар шүүлгэх эрх. Шударгаар шүүлгэх эрх нь аливаа хүн эрүүгийн хэрэгт татагдсан үеэсээ эхлээд ял шийтгэл эдэлж дуусах хүртэлх үе шатыг хамруулсан өргөн хүрээтэй ойлголт юм. Гэмт хэрэгт сэрдэгдэн шалгагдаж байгаа

хүнтэй мөрдөн шалгах, шүүх эрх мэдлийн байгууллагууд хэрхэн харьцаж байгаа, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрхийг хэрхэн хүндэтгэн хамгаалж байгаагаас тухайн улс дахь хүний эрх чөлөөний байдал, хууль дээдлэх ёс ямар түвшнийг илэрхийлэх шалгуур болдог. ХЭҮК-т 2024 онд ирсэн гомдол мэдээллийн 52,9 хувийг нь шударгаар шүүлгэх эрх зөрчигдсөн талаарх гомдол мэдээлэл эзэлж байгаа бөгөөд агуулгаар нь авч үзвэл өмгөөлүүлэх эрх, хууль зүйн туслалцаа авах эрх, хилс хэргийг хүлээсэн, эрүү шүүлтээс ангид байна, хууль бусаар цагдан хоригдсон, орон байрны халдашгүй байдалд халдсан, гэмт хэрэг үйлдсэн мэтээр олон нийтийн сүлжээнд урьдчилан зарласан, шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах байгууллагын алба хаагчдын хууль бус үйл ажиллагааны улмаас хохирсон зэрэг агуулгатай гомдлууд байна. Энэ бүлэгт комисст ирүүлсэн гомдол, мэдээлэл, зохион байгуулсан хяналт шалгалт, шинжээч, судлаач нартай хамтран боловсруулсан судалгааны үр дүн, комиссын гишүүний шаардлага, зөвлөмж, холбогдох байгууллагын баримт, мэдээлэлд үндэслэн шударгаар шүүлгэх эрхийн зарим асуудлыг хөндөж, цаашид давах арга хэмжээний талаар 10 саналыг тусгалаа.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос өргөн мэдүүлсэн Монгол Улс дахь хүний эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг хэлэлцэн цаашид авах арга хэмжээний талаар холбогдох шийдвэрийг гаргаж өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Илтгэлийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ХЭҮК-оос 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйлд заасны дагуу ХЗБХ 2024 оны, 25 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг Байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Сүнжид болон сэдэв тус бүрийг хариуцсан илтгэгч комиссын гишүүд танилцуулсан болно.

Монгол Улсын ХЭҮК уг илтгэлийг судалгаа, тайлан, хяналт шинжилгээ, үнэлгээ, иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл, дүгнэлтэд үндэслэн дараах 6 бүлэг сэдвийн хүрээнд бэлтгэсэн байна. Үүнд, 1.Монгол Улсын Их Хурал болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, шууд, тэгш эрхийн үндсэн дээр саналаа чөлөөтэй, нууцаар гаргах үндсэн зарчмыг хэрэгжүүлсэн байдалд дүн шинжилгээ хийж, шийдвэрлэх асуудлыг тодорхойлж, цаашид авах арга хэмжээний талаар. 2.Өмгөөлөгч, сэтгүүлчийн аюулгүй байдал, хууль тогтоомжийн хүрээнд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах боломж, баталгааг нэмэгдүүлэх талаар. 3.Цахим хөгжлийн суурь нөхцөл, хууль сахиулах, ял эдлүүлэх ажиллагаанд ашиглаж буй зарим төрлийн технологийн хүний эрхийн үнэлгээ, хиймэл оюун ухааны бодлого, зохицуулалт болон Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн хийдэл ба

хэрэгжилтийн талаар. 4.Цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийллийн өнөөгийн нөхцөл байдал, анхаарах асуудал, цаашид авах арга хэмжээний талаар. 5.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрх, хамгааллын асуудлын талаар. 6.Шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилт болон цаашид авах арга хэмжээний талаар тусгажээ.

Байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг мөрдөн байцаах, прокурор, шүүх зэрэг хяналтын байгууллага хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэний эрхийг зөрчиж буй эсэх асуудлыг тодорхойлж, эдгээр байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах, магадлангаар оруулж оруулах процессын тэгш шударга байдлыг хэрхэн хангах талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара Монгол Улсын ЗГ-аас хүүхдийн бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаа асуудлыг шийдвэрлэхэд зарцуулсан төсвийн үр дүнгийн талаар, хүүхэд хамгааллын төсөв нэмэгдэж байгаа боловч бэлгийн хүчирхийллийн эсрэг үр дүнтэй арга хэмжээ авах боломж хязгаарлагдмал хэвээр байгаа шалтгааны талаар. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын үйл ажиллагааны үр дүнг хэрхэн нэмэгдүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар Хүний эрхийн Үндэсний Комисс нь Монгол Улсын Их Хурлаас томилогддог байгууллагын хувьд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн хэрэгжилт, сэтгүүлчдийн эрхийг хамгаалах асуудалд хэрхэн анхаарч ажиллаж байгаа талаар өргөдөл гомдол гаргасан тоо баримт болон тэдгээрийн шийдвэрлэлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг 2019 онд Үндсэн хуульд оруулсан Улсын Их Хурлын сонгуультай холбоотой өөрчлөлтийн талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын байр суурийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21, 22, 23 дугаар илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлаас баталсан тогтоол шийдвэрүүдийн хэрэгжилтийг хэрхэн дүгнэж байгаа, эдгээр шийдвэрийн биелэлт хангалтгүй байгаа тохиолдолд илтгэл тайланг боловсруулах үр ашиг, ач холбогдлыг хэрхэн үнэлэх талаар шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд гарсан шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд ахиц гаргахын тулд ямар арга хэмжээ авсан талаар, салбарын холбогдох байгууллагууд сургалт, сурталчилгааны чиглэлд хэрхэн хамтран ажиллаж байгаа болон тухайн байгууллагуудын ажилтнуудын хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголт нь ямар түвшинд байгаа талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хүний эрхийн асуудал нь зөвхөн ХЗБХ-ны асуудал биш бөгөөд парламент цаашид ямар асуудал дээр бодлогын шийдвэр гаргах, ямар асуудал дээр зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээ авч, төрийн бусад байгууллагыг чиглүүлэн ажиллах зэргийг анхаарах талаар, хүний эрхийг хангах асуудал нь урт удаан хугацаанд үргэлжлэх процессын шинжтэй үйл явц гэдэг утгаараа түүнд зарцуулах төсөв хөрөнгө нэг удаагийн шинжтэй бус хэрхэн давтамжтайгаар төрийн бодлого, шийдвэрийг үргэлжлүүлэх гэдгээс хамаардаг тул илтгэлд тусгасан саналуудыг бодлогын шийдвэр, зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээ, төсөв санхүүгийн хүрэлцээгүйгээс шалтгаалж хүндрэл үүсэж байгаа асуудлууд зэргээр ангилж, тодорхойлох тусам, тодорхой тусгах шаардлагын талаар, мөн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилттэй холбоотой үүсэж байгаа болон цаашид үүсэж болзошгүй хүний эрхийн зөрчил, эрсдэлийг тооцож, илтгэлдээ тусгасан нь зүйтэй талаар, Үндсэн хуулийн цэц дээр үүсээд байгаа сонгуулийн хууль тогтоомжтой холбоотой

маргаануудыг холбогдох Байнгын хороод нь анхаарч, шаардлагатай бол ажлын хэсэг байгуулан сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагын талаар, мөн технологиос хүнээ хамгаалах бус технологи ба хүний эрхийн тэнцвэртэй байдлыг хэрхэн хангах, технологи эзэмшигчийн хариуцлагыг хэрхэн нэмэгдүүлэх зэрэг асуудалд анхаарах, Үндсэн хуульд заасан шударга шүүхээр шүүлгэх эрхийг шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилт гэж томъёолон тусгасан нь зөв зүйтэй талаар тус тус байр сууриа илэрхийлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.5 дахь хэсэгт энэ хуулийн 115.2.3, 115.2.15-д заасан илтгэл, тайланг холбогдох Байнгын хороо нэгдсэн хуралдаанд заавал танилцуулах бөгөөд бусад тайлан, илтгэл, мэдээллийг холбогдох Байнгын хороо хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл нэгдсэн хуралдаанд танилцуулж болно гэж заасны дагуу Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 24 дэх илтгэлийг хэлэлцсэн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: Сандаг-Очир гишүүнд талархал дэвшүүлье. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Дугарын Сүнжид Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Жаргалсайханы Хунан Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Ганбатын Нарантуяа Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Сангишаравын Дондов Хүний эрхийн Комиссын гишүүн, Батзэвэгийн Энхболд Хүний эрхийн Комиссын гишүүн, Галбадрахын Ууганбаатар Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд одоо нэрээ өгөх ёстой байгаа. Гэхдээ өглөө Ардчилсан намын бүлгийн дарга Цогтгэрэл дарга хэлэлцэх асуудалтай холбогдуулаад Хүний эрхийн Комиссын илтгэлтэй холбоотой асуудал дээр завсарлага авахгүй, чуулганы хуралдаанд оролцоно гэж өглөө илэрхийлж байсан. Тэгэхээр чуулганыхаа хуралдаанд орж ирж, хүний эрхийн чухал асуудлаар хэлэлцэж байгаа учраас нэрээ өгч, чуулганы хуралдаандаа идэвхтэй оролцохыг хүсэж байна. 5 минутын хугацаа өгье. Гишүүдийн нэр авахаас өмнө, гишүүдийг орж ирж асуулт асуух, үг хэлэх нэрээ өгөх шаардлагатай гэж үзэж байна. 5 минутын хугацаа.

Тэгээд ер нь энэ Улсын Их Хурлын үйл ажиллагаа гэдэг бол хэн нэг хүний ч гэдэг юм уу, хэсэг бүлэг нөхдийн хоорондоо ойлголцоогүй, бие биеийгээ эмзэглүүлэх үг хэлсэнтэй холбогдож, гацаж, саатаж байдаг зүйл огтоос биш. Би өглөө завсарлага өгөхдөө ч тодорхой хэлсэн. Өнөөдөр завсарлага өгсөн шалтгаан бол хэн нэгэн уучлалт гуйх, гуйхгүйтэй холбоотой асуудал огт яригдаагүй. Дэгийн тухай хуулиараа, Улсын Их Хурлын тухай хуулиараа хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж завсарлага авдаг. Тэгээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан завсарлага авсан. Хэрвээ хамтарсан ЗГ байгуулсан Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН нам зэрэг намуудын хооронд үл ойлголцол улс төрийн

асуудал байгаа бол энэ хамтарсан ЗГ байгуулахаар гарын үсэг зурцгаасан тэр Зөвлөл хоорондоо уулзаж, асуудлаа ярих хэрэгтэй. Тэгэхгүйгээр ингээд нэг нэгэндээ гомдсон, туньсан байдалтайгаар Улсын Их Хурлын үйл ажиллагааг тасалдуулж болохгүй.

Энд төрийн ажил явж байгаа. Аль, аль талдаа зарчимтай хандах ёстой. Аль, аль талдаа хүндэтгэлтэй хандах ёстой. Цаашдаа яах юм Улсын Их Хурлын чуулган дээр 2 гишүүн хоорондоо үг чулуудсанаас болоод Улсын Их Хурлын үйл ажиллагаа гацаж саатаад сууж байдаг ийм жишиг рүү бид орох юм уу. Би бол тийм жишигт оруулахгүй. Энэ үйл ажиллагаа тогтвортой, хэвийн явж байх ёстой. Хэрвээ асуудал байгаа бол хамтарсан ЗГ байгуулахаар гарын үсэг зурцгаасан улс төрийн намын удирдлагууд, намын дарга нар, тэр Ерөнхий нарийн бичгийн дарга нар, тэр Бүлгийн дарга нар, тэр улс төрийн намын удирдлагууд хоорондоо асуудлаа ярьцгаа. Энэ бол Улсын Их Хурлын асуудал огтоос биш шүү. Хэрвээ ийм байдалтай байгаа бол Улсын Их Хурал ч гэсэн өөр арга хэмжээ авч болно шүү дээ. Хэндээ эрхлээд байгаа юм, ард түмэнд эрхэлнэ гэж байхгүй шүү дээ. Ард түмэн ажлаа хий гээд сонгочихсон, ард иргэдийн аж амьдрал тийм сайхан байна гэж бодож байгаа юм уу. Танхим дотор нэг хэрүүл хийгээд сууж байхаас ард түмнийхээ амьдралыг, аж амьдралыг яаж сайжруулах вэ, орлогыг нь яаж нэмэх вэ, энэ үүсээд байгаа эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой асуудлыг хэрхэн даван туулах вэ гэдэг асуудал дээр өнөөдөр хэрэлдээд сууж байх ёстой шүү дээ.

Гэтэл энд нэг ялих шалихгүй асуудлуудаар хэрүүл хийгээд, бойкот хийх гээд сууж байдаг. Би аль, аль намд нь зориулж хэлж байгаа шүү. Хэн нэгэн хүнд зориулж хэлээгүй. Улс төрчид ер нь зарчимтай байх ёстой шүү. Тэгэхээр 5 минутын хугацаа өгье. Орж ирж асуулт асуух, үг хэлэх нэрээ өгөх ёстой.

14 цаг 29 минут болсон байна. 5 минутын хугацаа өгсөн. Алтангэрэл сайд, Эрдэнэбүрэн сайд, Батсуурь сайд 3 орж ирсэн байна. Манай Хууль зүйн сайд энэ Хүний эрхийн Комиссын илтгэлтэй холбоотой асуудал дээр орж ирж сууж байгаа нь маш зөв. Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаар илтгэл явж байгаа. Чуулганы хуралдаанаа үргэлжлүүлье. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлэх нэрсээ өгье. Улсын Их Хурлын дэд дарга Булгантуяа гишүүнийг нэмье, Бум-Очир гишүүнийг нэмье амжиж кноп дараагүй байна. Ингээд нийт 16 гишүүнээр, Алтангэрэл сайдыг нэмж өгье, Идэрбат гишүүнийг нэмж өгье. Ингээд нийт 17 гишүүнээр тасаллаа. Ирсэн ирцийн дарааллын дагуу Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууж, үг хэлье.

О.Номинчимэг: Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд юуны өмнө энэ Хүний эрхийн Комиссоос оруулж ирж байгаа 24 дүгээр илтгэл энэ жилийн хамгийн онцлох сэдвүүдээр 6 маш чухал иргэдэд тулгамдаж байгаа, манай хууль зүйн тогтолцоо, хүний эрхийг хамгаалах тогтолцооны гол, гол чухал асуудлыг хөндөж ирсэн энэ илтгэлийг хэлэлцэх гээд ингээд байж байхад АН-ын бүлгийн гишүүд маань орж ирэхгүй, албан ёсоор завсарлага аваагүй боловч энэ илтгэлийг хэлэлцэхгүй байгаад туйлын харамсаж байгаагаа илэрхийлмээр байна. Өнөө өглөө ч гэсэн Зээлийн мэдээллийн сангийн тухай хууль гээд энэ хар жагсаалт гэдэг юмыг байхгүй болгож, санхүүгийн хэрэглэгч, иргэддээ ээлтэй болгох хуулийн зөвхөн санал хураалт явах байсан, бүгд дэмжиж байгаа гэдэг саналыг Байнгын хороо, чуулган дээр илэрхийлж байсан боловч бүлэг дээрээ саналаа нэгтгэх шаардлагатай гэсэн худлаа үндэслэлээр ингээд завсарлага авч байгаад улс

төржилтийг энэ иргэддээ хэрэгтэй хуулийг явуулахад түргэн шуурхай ажиллахад саад болгож ингэж ашиглаж байна гэж харж байна.

Энэ жилийн хүний эрхийн комиссоос гаргаж байгаа энэ илтгэл маш чухал ийм 6 сэдвээр тавигдсан байгаа. Ялангуяа 24 онд сонгууль болсон, сонгох, сонгогдох эрхийн талаар 24 оны сонгууль яаж, хэрхэн өнгөрөв, юун дээрээ анхаарах ёстой байна вэ? Мөн энэ хүүхдийн хүчирхийллийн асуудал, цахим орчин дахь хүний эрхийн асуудлаа бид яах вэ. Бид Улсын Их Хурал дээр нэлээн анхаарч ажиллаж байгаа. Шударгаар шүү шүүлгэх эрхийн хэрэгжилтийн хүрээнд эрүүдэн шүүлтийн асуудал гээд энэ чухал асуудлуудыг гаргаж тавьсан байгаа. Улсын Их Хурлаар шийдвэр гаргуулахаар өгсөн саналууд бүгд энэ, энэ сэдвүүд дээр байгаа. Миний хувьд энэ дээр илүү асуулт гэхээсээ илүү бид мэдээж энэ илтгэлийг нарийвчлан сайн хэлэлцсэнийхээ дараа Улсын Их Хурлаар тогтоол гаргадаг. Энэ тогтоолоо хэрэгжилтийг нь хангах механизм болгоод түрүү жилээс хойш хэдэн сарын дараа Байнгын хороон дээрээ энийгээ хэлэлцдэг болсон, хэрэгжилт нь яаж байна гэдэг асуудлыг.

Тэгээд бид энэ асуудлаа хэрэгжилтийнх нь хүрээнд харвал Засгийн газар луу ямар, ямар чиглэлүүдийг өгөх вэ? Хууль тогтоомжийг сайжруулах, засах асуудлуудыг нь Улсын Их Хурал ямар үүрэгтэй оролцох вэ, салбарын томоохон бодлогын хуулиудаа Засгийн газар тэгвэл яаж оролцох вэ гэдгийг Улсын Их Хурлын тогтоол гаргахдаа нэлээн сайн анхаарч хугацаатай үүрэг өгмөөр байгаа юм. Тэгэхгүй бол яг үнэнийг хэлэхэд энэ асуудал хугацаагүй байгаагаас эсвэл хэнд нь оноож байгаагаас, оноож байгаа нь тодорхойгүйгээс ингээд цалгарддаг, дараа нь хэрэгжилт нь байхгүй асуудал болдог, дахиад л энэ асуудал маань ингээд явдаг асуудал байдаг. Энэ дээр ялангуяа бид Улсын Их Хурлын хувьд энэ сонгуулийн зардлыг бууруулах чиглэлээр тусгай арга хэмжээг хуулиар тодорхойлох шаардлагатай байна гэдгийг анхаарч, Улсын Их Хурал өөрөө анхаарах ёстой болов уу гэж бодож байна.

Нөгөө талаар энэ шударгаар шүүлгэх эрхийн хүрээнд бид хуулийн асуудлуудыг, зохицуулалтуудыг хийх юмнууд байна. Гэхдээ ер нь энэ салбарын яам Хууль зүй, дотоод хэргийн яам маань энд бугширсан системийн эрүүдэн шүүлт, энэ гүйцэтгэх ажиллагааг эсвэл энэ гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх сангийн зарцуулалт ямар байна гэдэг яг энэ бодлогын салбарын хувь хүрээнд хэрэгжилт нь ямар байна, тогтолцооны хувьд ямар байна гэдэг нэлээн том судалгааг хийж, нэлээн том үнэлэлт дүгнэлт өгсний дараа хуулиа боловсруулах энэ ажлыг анхаараач. Олон ч энэ санал зөвлөмжүүд гарч байгаа. Одоогоор яг энэ эрүүдэн шүүлттэй холбоотой Улсын Их Хурал дээр нээлттэй хэлэлцүүлэг хяналтын сонсгол болсон. Бас нэг хамгийн том энэ дээр яригдсан сэдэв бол ерөөсөө хохирлоо нөхөн төлүүлж чаддаггүй ийм системтэй. Ер нь манай энэ Гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэх сангийн зарцуулалт, журам нь ямар ч оновчгүй юм байна лээ. Нэг залилангийн хэргийн хохирлыг нь барагдуулаад, яг ийм хүнд гэмт хэргийн хохирогчид эсвэл бүр нас барчихсан хохирогч, эсвэл насаараа ингээд шоронд орчихсон хүмүүсийн хохирогчид юу ч өгөхгүй, энэ хүмүүс маань гэмт хэргийн хохирогч болоод дээр нь насаараа эдийн засгийн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Номинчимэг гишүүнд 1 минут нэмж өгье.

О.Номинчимэг: Гэмт хэргийн хохирогчид маань 1 дүгээрт гэмт хэргийн хохирол, эдийн засгийн хувьд, бие махбодын хувьд, дараа нь сэтгэлийн, сэтгэл зүйн хувьд ингээд насаараа хохироод, энийгээ хэзээ ч нөхөн төлж авах чадахгүй байдалтай явж байгаа олон хүн байна, Улсын Их Хуралд ч гэсэн хандаж байна. Энэ хүмүүсийнхээ бид хохирлыг яаж, ямар эрэмбэ дараатай төлүүлэх вэ, буруутай этгээдээс нь яаж энэ хохирлыг нь гаргуулах вэ гэдэг дээр нэлээн бодлогын сайн чамбай юм гаргахгүй бол энэ өдөр ирэх тутам л энэ санал гомдол, асуудлууд салбарынхнаас, иргэдээс ирж байгаа гэдгийг Хууль зүйн сайд анхаараасай гэж хүсэж байна.

Дахиад нэг анхаарах зүйл бол нэг талаас үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих, нөгөө талаас худал мэдээлэл, хүчирхийлэл, үзэн ядалтыг дэвэргэх, илэрхийлэх, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй хоруу контентыг хязгаарлах энэ бодлогыг төр хийгээч гэдгийг энэ Хүний эрхийн Комиссоос зөвлөмж болгожээ. Бид энэ дээрээ яалт ч үгүй Улсын Их Хурлын түвшинд ч гэсэн, ЗГ-ын холбогдох яамдын түвшинд ч гэсэн энийгээ анхаарахгүй бол энэ худал мэдээлэл гэдгээр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Хэн хариулах вэ? Үндсэндээ санал. Дуламын Бум-Очир гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Бум-Очир: Энэхүү илтгэлд сэтгэл эмзэглүүлэм тоо баримт байгааг та бүхний анхааралд хандуулах гэсэн юм. Энэ бол илтгэлийн 320-оос 331 дүгээр талд байгаа насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдлын тухай хэсэг. Энд 2020 оноос 24 оны статистикийг танилцуулсан байгаа. 14-өөс 17 настай хохирогч болсон хүүхдийн тоо 66-аас 119 болж өссөн байгаа. Бага насны хүүхдийн тоо 138-аас 247 болж өссөн байгаа. Энэ тасралтгүй өсөөд байгааг энэ Хүний эрхийн Үндэсний Комиссынхон хэлсэн. Сүүлийн жилүүдэд хуулийн заалтыг чангатгасан, ял шийтгэлийг хүндрүүлсэн. 2020 онд сэрэмжлүүлье гэдэг арга хэмжээ авсан, 2022 онд мөн, уучлаарай түрүүн 2022 он шүү бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдүүдэд туслалцаа үзүүлэх сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Гэсэн хэдий ч энэ тоо ерөөсөө буурахгүй өсөөд байгааг бид бүхэн ялангуяа эцэг, эхчүүд анхаарах шаардлагатай байна.

Миний бодлоор бууруулахын тулд энэ гэмт хэргийн онцлогийг бид анхааран судлах шаардлагатай байгаад байгаа юм. Ямар онцлогууд байна вэ гэхээр нэгд энэ гэмт хэрэг гол төлөв тухайн хүүхдийн гэр оронд юм уу эсвэл хамаатан садны гэр оронд үйлдэгдээд байгааг бид онцлох ёстой. 2-т үүнээс улбаалан энэ гэмт хэргийг гол төлөв гэр бүл, хамгийн харамсалтай нь гэр бүл, хамаатан садны хүн үйлдэж байгаа гэх мэдээлэл байдаг. Нөгөө талаар ялангуяа бага насны хүүхэд гэрээсээ юм уу, хамаатан садны гэрээс өөр газар хараа хяналтгүй байж энэ гэмт хэргийн хохирогч болох нөхцөл бололцоо бага гэдгийг бид бүгдээрээ мэдэж байгаа.

Дээрх энэ онцлог байдал дараах үр дагаварт хөтлөөд байна гэж харж болохоор байгаа юм. Нэгд олон нийтэд мэдээлэх нь нийгмийг сэртхийлгэх цочроох болзошгүй гэдэг эмзэг сэдэв учраас тэр болгон олон нийтэд мэдээлээд байдаггүй өнгөрдөг. 2-т гэр бүлийн юм уу, хамаатан садны хүн гэмт хэргийг үйлдэх тохиолдол их байдаг тул хэргийг хэрэг үүсгэхгүй байх тохиолдол байгаад байна. Тиймээс хохироод шинжилгээ хийлгэсэн хүүхдийн тоо хэрэг үүсгэсэн тоо 2 нэлээд их

зөрөөтэй байгааг та бүхэн илтгэлээс харж болно. Өөрөөр хэлбэл энэ хэргийн тоо магадгүй бидэнд мэдэгдэж байгаагаас илүү байж болзошгүй юм гэдгийг энд онцлон дурдмаар байна. 3-д гэр бүлийн орчинд энэ гэмт хэрэг гарах тохиолдол их байна гэдэг бол нөгөө талаар эцэг, эх, асран хамгаалагчийн хариуцлагын тухай асуудал хөндөгддөг. Энэ нь мөн хэрэг үүсгэхгүй байх шалтгаан болж байх магадлалтайг мөн дурдмаар байна. 4-д хэргийг мөрдөн шалгах үйл явцад эргээд хохирогчийн нэр хүнд, сэтгэл санаанд эрсдэл учруулах магадлалтай байдаг. 5-д эцэг, эх, асран хамгаалагч урьдчилан сэргийлье гэхэд ойр дотнын гэр бүлийн гишүүдээ харамсалтай нь хардах шаардлагатай болдог. Мэдээж энэ нь эвгүй харилцаа үүснэ. Гэр бүлийн юм уу, хамаатны хүн хүчирхийлэгч байна гэж огт боддоггүй. Тийм учраас урьдчилан сэргийлэх боломжийг тодорхой хэмжээгээр энэ нөхцөл байдал хязгаарлаад байна.

Хэдийгээр тийм боловч бид эцэг, эхчүүдээ анхааруулах нь шаардлагатай юм шиг хэлж, бодож байна. Хэдийгээр энэ харилцаа эвгүй боловч уучлаарай хүчирхийлэгч таны ойр дотнын хүн байна шүү, гэр оронд чинь байна шүү гэдгийг эцэг, эхэд анхааруулах, тогтмол сэрэмжлүүлэх үйл ажиллагааг хэдийгээр нийгэмд эвгүй боловч бид хүүхдүүдээ ингэж магадгүй хамгаалахаас өөр гарц үлдэхгүй байгаа юм болов уу гэж санагдаж байна. Энэ тал дээр ХЭҮК ямар байр суурьтай, ямар арга зам байгаа вэ? Ямар арга зам, шийдлийг санал болгож байгааг би энэ ташрамд сонсохыг хүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон хариулт өгье.

Ж.Хунан: Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр үнэхээр сэтгэл эмзэглэм ийм тоо баримт байна. Тэгээд энийг бид бүгдээрээ мэддэг, хуулийн байгууллагууд судалдаг, шалтгаан нөхцөлийг нь тодруулдаг хэдий ч ингээд үр дүн гарахгүй байгаад бид дахин дүгнэлт хийх хэрэгтэй юм байна. Бидний зүгээс ямар санал гаргаж байна вэ гэхлээр энэ төрлийн гэмт хэргийг бүүр дэлгэрэнгүй нарийвчилсан судлах ийм хэрэгцээ шаардлага байна гэж байгаа юм. Өмнөх хийж байгаа, өмнө нь хийгдсэн судалгаанууд үндсэндээ байгууллагын түвшинд өөрөөр хэлбэл Цагдаагийн ерөнхий газар, прокурор, дээрээс нь эрдмийн зэргийн цол зэргийн хамгаалах үүднээс хийгдсэн судалгаануудад ингээд хийгддэг. Энэ нь хязгаарлагдмал хүрээнд үндсэндээ ашиглагдаад ингээд үлдчихнэ. Тэгэхээр энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог, өөрөөр хэлбэл энэ төрлийн гэмт хэргийг, гэмт хэргийн асуудлаар ажилладаг байгууллагуудыг, байгууллагуудын төлөөллийг оролцуулсан ийм өргөтгөсөн ажлын хэсэг гаргаж, энэ дээр маш дэлгэрэнгүй судалгааг дахин хийж, шалтгаан нөхцөл, дээрээс нь энэ чиглэлээр авч хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх, тэмцэх ямар арга хэрэгсэл байх вэ гэдгийг гаргаж ирэх ийм ажлын хэсгийг байгуулж, ийм судалгааг хийх шаардлагатай гэж харж байгаа.

Д.Амарбаясгалан: Бум-Очир гишүүн тодруулж асууя.

Д.Бум-Очир: Баярлалаа. Энэ ташрамд би нэг зүйлийг дурдаад захиас гэх үү зүйл Хүний эрхийн Үндэсний Комиссынхондоо хэлмээр байгаа юм. Тэр юу вэ гэхээр орон нутагт явж байхад нэг ийм сонирхолтой тохиолдол гарсан. Тэр юу вэ гэхээр энэ хүүхдүүд зөвхөн эрхтэй гэж, бид хүүхэд бол эрхтэй, үүрэггүй гэдэг ойлголт авсан. Сургалтын явцад ийм мэдээлэлтэй болсон. Ингээд сурагчид маань даалгавраа хийх үүрэггүй, эцэг, эхээ хүндлэх, багшийнхаа үгэнд орох үүрэг

хүлээхгүй гэдэг ийм ойлголт нийгэмд тодорхой хэмжээгээр бий болсон тухай яг ажлаар явж байхад сонсож байсан. Магадгүй энэ нөгөө талдаа ХЭҮК ажлаа сайн хийж, энэ хүний эрхийн асуудлыг сайн сурталчилж байгаа явдал болов уу гэж бодож байна. Нөгөө талдаа миний хүсмээр байгаа зүйл юу гэхээр энэ үүрэг хариуцлагын тухай асуудлыг яг эн тэнцүү адилхан ойлголтыг нийгэмд сурталчилж өгөөч. Үүн дээр анхаараач гэдгийг онцгойлон хүсмээр байгаа юм. Ингээд та бүхний ажилд амжилт хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

А.Ариунзаяа: 1889 оноос хойш дэлхийн улс орнууд Олон улсын хөдөлмөрчдийн өдрийг 5 сарын 1-нээр тэмдэглэдэг ийм уламжлал тогтоод байна. Та бүхэндээ Олон улсын хөдөлмөрчдийн өдрийн мэндийг хүргэе. Хөдөлмөр бол хүний эрх юм, хөдөлмөр хүний үүрэг ч юм. Улсын Их Хурлын гишүүдийн хөдөлмөр гэдэг бол Улсын Их Хурлын чуулгандаа суух, хөдөлмөрлөх үүргээ хүлээхгүй байгаа АН-ын гишүүдэд харамсаж байна. Батсуурь, Алтангэрэл, Эрдэнэбүрэн сайдууд сууж байна. Үнэхээрийн хүний эрхийн мэдрэмжтэй юм байна, сайн үүргээ хүлээж байгаа юм байна.

Улсын Их Хурлын дарга Амарбаясгалангийн санаачилгаар парламентын 3 төгөлдөршил явагдаж байгаа. Ахмад настны хөтөлбөрийг өнөөдөр бид зарласан. Ахмадын хөдөлмөрлөх эрхийг бид онцолсон байгаа. Хөдөлмөр эрхлэлтийн Хөдөлмөрийн тухай хуулиар тухайн тэтгэврийн насанд хүрсэн хүний өөрийнх нь хүсэлтээр нь л ажлаас нь чөлөөлнө. Ажил олгогчийн санаачилгаар, шахалтаар ажлаас нь чөлөөлж болохгүй гэж заасан байгаа. Нийгмийн даатгалын тухай хуулиар ч тэр тодорхой насанд хүрсэн бол өөрийн хүсэлтээр тэтгэврээ тогтоолгоно гэсэн заалтууд байгаа. Тэгэхээр энийг ч гэсэн ташрамд хэлж, 50-аас дээш ажилтантай ААН байгууллагууд өмчийн хэлбэр үл хамааран 2-оос доошгүй хувьд ахмадыг ажиллуулах үүргийг хүлээж байгаа. Ингэж ажиллуулахдаа тэтгэврийн шимтгэлийн 8,5 хувийг ажилтан болон ажил олгогч аль аль нь төлөхгүй байх ийм зохицуулалтыг хийснийг ташрамд хэлье. Төрөөс ер нь ахмадууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүдийн талаар онцгой анхаардаг. Яагаад гэвэл энэ хүмүүс өөрсдийгөө хамгаалж чаддаггүй субъектүүд учраас.

Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Сүнжидэд би талархлаа дэвшүүлмээр байна. Хүүхдийн асуудлыг нэн тэргүүнд танилцууллаа. Осол гэмтлийн сүүлийн 5 жилийн статистик мэдээллийг Эрүүл мэндийн яамнаас гаргасан. Би энэ номыг ойрд маш ихээр хэрэглэж, статистик мэдээллүүдийг харж байгаа. 2019-өөс 23 онд 5 жилийн хугацаанд осол гэмтлийн улмаас эрүүл мэндийн байгууллагад хандсан 844 мянган хүн байгаа. Үүнээс 0-14 насны 260 мянган хүүхэд осолд өртсөн байна. Энэ дотроо хүчирхийллийн улмаас 19-өөс 23 онд 0-14 насны 4262 хүүхэд эрүүл мэндийн байгууллагад хандсан байна. Зам, тээврийн ослын улмаас эдгээр 5 жилд нийт 320 0-14 насны хүүхэд нас барсан байна. Осолд ороод нас барсан байна, маш харамсалтай. 0-4 насны 140 хүүхэд, 5-9 насны 79 хүүхэд, 10-14 насны 101 хүүхэд. Амиа хорлолт сүүлийн 5 жилд 5-9 насны 9 хүүхэд, 10-14 насны 65 хүүхэд, 15-19 насны 179 хүүхэд, нийтдээ 253 хүүхэд амиа хорлосон байна.

Бид үнэхээр хүүхдээ хамгаалж чаддаггүй. Хүүхдийн байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ой 5 сарын 8-нд болно. Хүүхэд хамгаалах үүрэг зөвхөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд байгаад байдаг асуудал огт биш, огтоос биш. Иргэн бүр үүнд анхаарах ёстой, иргэн бүр үүнд хариуцлага хүлээж байх ёстой. Бум-Очир гишүүн түрүүн хэллээ. Гэр бүлийн хүрээнд хүүхдийн бэлгийн хүчирхийллийн асуудал яваад байна гэж. Зөвхөн 2024 онд шүүх шинжилгээний байгууллагад 908 хүүхэд хандахад 598 нь цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн байгаа. Цаана нь далд мэдэгдэхгүй байгаа 310. Бага насны хүүхдийн хүчирхийлэл маш их байгаа нь тухайн эрүүл мэндийн байгууллагад үр хөндүүлж байгаа, мөн төрж байгаа хүүхдийн тоогоор ч гэсэн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Асуултад хариулъя. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Ж.Хунан: Статистик, Ариунзаяа гишүүний асуултад хариулаад статистик мэдээллийг харвал үнэхээр харамсмаар байна. Өнөөдөр Монгол Улс хүүхдээ хамгаалж чадахгүй байна гэдэг дүгнэлтийг хийж байгаа. Тэгэхээр энийг бид бүх түвшиндээ анхаарах ёстой. Дээрээс нь бид нэг зүйлийг энэ дээр онцгойлон хэлмээр байгаа. Нөгөө хүүхэд 1 дүгээрт гэдэг зарчим бүрэн дүүрэн хэрэгжихгүй байгаагийн илрэл ерөөсөө энэ гэж харж байна. Хүүхдийн дээд ашиг сонирхол гэдэг зүйлийг бид Хүүхдийн эрхийн конвенц, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиараа бид баталгаажуулсан боловч амьдрал дээр энэ маань үнэхээр бүрэн дүүрэн хэрэгжихгүй байгаа. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрхийг хамгаалах журам жишээ нь шинэчилсэн найруулсан Хүүхэд хамгааллын тухай хуулиар гарах ёстой байтал өнөөдрийг хүртэл гараагүй явж байна. Гэтэл уг хууль маань өнгөрсөн оны 1 сард батлагдсан, 9 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн ийм хууль.

Тэгэхээр хүүхдийн асуудлыг бид энэ томчуудаас хараат байдаг энэ амьгүй бид нарын томчуудын үгээр байдаг мэт ингэж хандаж ирсэн нь өнөөдөр ийм нөхцөл байдалд хүргэж байгаа. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, өнөөдөр Монгол Улсад хүний эрхийн соёлыг төлөвшүүлэх асуудал учир дутагдалтай байгаатай шууд холбоотой гэж хэлж болно. Тэгэхээр энэ дээр бид онцгой анхаарал хандуулах зайлшгүй шаардлага байна гэж харж байгаа. Хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой мөн орхигдсон хэд хэдэн асуудлууд байгаа. Дээрээс нь энэ статистик өсөж байгаагийн нэг шалтгаан нь энэ Эрүүгийн хуулийн 14 дүгээр зүйлд заасан 14 наснаас доош настай хүүхэдтэй, 14-өөс доош насны хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох асуудал байгаад байгаа. Бэлгийн бойжилт өнөөдөр эрт эхэлдэг болсонтой холбоотойгоор 13 настай, 14 настай хүүхдүүд хоорондоо үерхэж, бэлгийн харьцаанд орох тохиолдлууд гарч байна. Энэ тохиолдолд хуулийн тэр зөвхөн заалтаар шууд гэмт хэрэгтэн болох явдал нийтлэг түгээмэл байна. Энэ нь өсөж байна.

Тэгэхээр энэ нөхцөл байдлыг бид хүлээн зөвшөөрч, энэ бэлгийн боловсролыг хүүхдүүдэд багаас нь олгох, энэ бэлгийн дарамт хүчирхийллээс өөрийгөө урьдчилан сэргийлэх, бусдыгаа хэрхэн яаж хамгаалах гэдэг энэ сургалт мэдлэгийг олгох хэрэгцээ шаардлага байгаад байгаа. Ялангуяа энэ бага насны хүүхдүүдтэй холбоотойгоор бэлгийн гаж зан үйлтэй буюу педофил хүмүүсийг өнөөдөр Монгол Улс оношилдог, тогтоодог энэ зохицуулалт байхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ бага насны хүүхэдтэй бэлгийн харьцаанд орж таашаал авдаг хүмүүс буюу энэ педофил хүмүүсийг бид шинжилдэг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Хүүхдүүдийн өмнө томчууд бид л үүрэг хүлээж байгаа юм. Тэгээд энэ бэлгийн хүчирхийллийг бид нэг тохиолдол ч юм уу, нийтэд мэдэгдэхлээрээ нийтээрээ цаазаар ав, ялыг нь нэм гэж л яриад байдаг. Гэтэл цаана нь мэдэгдэхгүй маш олон тохиолдлууд байна шүү дээ. Энэ тоон судалгаан дээр сүүлийн 20-оос 24 онд 0-6 насны 350 хүүхэд байна шүү дээ. 7-13 насны 1395 хүүхэд байна шүү дээ. Энэ болгоныг бид ярихгүй байгаа байхгүй юу. Томчууд хүүхдийг хүчиндээд шоронд орж байвал миний бодлоор уг нь тэр тариаг нь л тарьчихмаар байгаа юм. Гэтэл тухайн хүний хүний эрх гэж яриад байх юм. Би тэрийг ердөөсөө огт ойлгохгүй байна. Саяын Хунан гишүүний хэлж байгаа асуудал маш зөв. Нөгөө хүүхдүүд хоорондоо үерхээд асуудалд орвол яах вэ гэж. Тухайн хүүхдүүдийн өмнө эцэг, эхчүүд хариуцлага хүлээж байгаа болохоос биш 2 хүүхэд хоорондоо үерхээд, бэлгийн харьцаанд орлоо гэхэд эрэгтэй хүүхдийг нь хорьдог нь ямар учиртай юм бэ.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн асуулт асууж, үг хэлье.

Н.Алтаншагай: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байгаа дүү нартаа баяр хүргэж, сургалтад сурлагад нь амжилт хүсье. Тэгээд хүүхдүүд орж ирж таарлаа. Хүүхдүүдийн эрхийн талаар бид бүхэн нэлээн нухацтай ярилцаж байна. Тэгээд гишүүд ярьж байна энэ хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой асуудал далд хэлбэрт шилжсэн нь үнэн. Энэнээс бид бүхэн урьдчилан сэргийлж чадахгүй байгаа. Бодит үр дүнд хүргэж чадахгүй байгаа. Энэ чиглэлээр яг соён гэгээрүүлэх яг ямар бодит ажлыг ХЭҮК хороо хийсэн бэ? Энэ дээр 1 дүгээрт нэг тайлбар авъя.

2 дугаарт энэ их, дээд сургууль дээр байгаа энэ оюутан суралцагч нартай холбоотой зөрчилтэй эрхтэй холбоотой асуудлууд, гомдлууд их ирдэг, байж байдаг. Сургуулиа төгсөж чаддаггүй, янз бүрийн хавчлага шахалт дарамт үзүүлдэг, багш нараас нь, сургалтын албанаас нь 3, 4 жил төгсгөөгүй хүүхэд байгаа шүү дээ, би яриад л яваад байгаа юм. Холбогдох мэдээллийг нь яаманд нь өгсөн. 4 жил сургуулиа төгсөж чадаагүй, энэ хавар төгсөх нь үү, үгүй юу. Би холбогдох газруудад нь бүгдэд нь уламжилсан байгаа.

Дараачийнх нь төрийн албан хаагч нарын асуудал байгаа юм. Сонгууль болгоны дараагаар энэ хөндөгддөг асуудал. Намын харьяаллаар дарга, цэрэг солигдохоор ингээд дагаад энэ мөрөөрөө ажлаа хийж явсан төрийн албан хаагчид өртөж эхэлдэг. Янз бүрийн шахалт дарамт үзүүлдэг. Тэгээд өөрөөр нь нэг өргөдлийг нь бичүүлээд авсан болоод ингээд хаагаад явдаг. Тэгээд ХЭҮК гэдэг юм 461 дүгээр хорих ангид хүн эндлээ, асуудал үүслээ гэхээр л нэг шуугьсхийгээд л ингээд өнгөрдөг. Энэ байдал дээрээ яг бодит дүгнэлт хийж, та бүхэн маань энэ соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх энэ чиглэлээр яг ямар бодит ажил хийгээд, яг бодит үр дүнд хүрч байна вэ? Энэ дээр хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Ж.Хунан: Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комиссын хуулиар хүлээсэн нэг чиг үүрэг бол хүний эрхийн соёл, боловсролыг түгээх, дэлгэрүүлэх гэдэг ийм байгаа. Тэгээд үндсэндээ нэг бүхэл ажлын бүрэлдэхүүн хэсэг бол энэ хүний эрхийн мэдлэг, боловсролыг түгээх. Энэ хүрээндээ хүүхдийн эрхийн асуудалд онцгойлон анхаарал хандуулдаг гэдгийг танд албан ёсоор мэдэгдье. Алба хаагчдад сургалт явуулахаас гадна бид энэ сурталчилгаа нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулдаг. 10 жилийн хүүхдүүдтэй холбоотойгоор хүний эрхийн түгээмэл тунхаглал манай ангид гээд нэгдсэн арга хэмжээг 9 сарын 1-нд зохион байгуулж байна. 6 сарын 1-нд хүүхдийн марафон гээд үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийллээс ангид байх асуудлаар арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна. Хүн бүр хүүхэд хамгаалагч гээд дуудлагыг эхлүүлчихсэн ингээд явж байгаа.

Тэгэхээр байгууллагууд, ААН-үүд, иргэд комисст хандаж сургалт авах, авахаас гадна олон нийтийн сүлжээ болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх ажлыг бол тогтмол авч хэрэгжүүлдэг. Мэдээжийн хэрэг үр дүн нь тэр дороо гардаггүй, урт хугацаандаа гарах тохиолдол байдаг. Тэгэхдээ Хүний эрхийн Үндэсний Комиссын энэ сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлын үр дүнд ахиц дэвшил гарч байгаа гэдэгт итгэлтэй байна.

Д.Амарбаясгалан: Алтаншагай гишүүн тодруулж асууя.

Н.Алтаншагай: Сошиал орчинд ялангуяа энэ 10 жилийн хүүхдүүд бүлгидүүлэх, сошиал дарамтад өртөх ийм хүнд хэлбэрийн эрүүгийн ч харьяалалтай ийм ноцтой асуудлууд гарч байсан. Тэгээд Сонгинохайрхан дүүрэгт байхдаа энэ 10 жилийн 10, 11, 12 дугаар ангийн төгсөх сурагчдад зориулсан 18 дахь хаврын хайр гээд энэ анги, хамт олны болон энэ багш нарын амьдралыг харуулсан нэг ийм жүжиг Хүүхэд залуучуудын театрт тавигдаж байсан. Энэ бол нэлээн үр өгөөжөө өгсөн ийм арга хэмжээ байсан. Энэ юунаас болж хийгдсэн жүжиг юм бэ гэхээр алга болоод хүнд байдалд орж байсан тухайн үедээ тэр охины эрхийг хамгаалах чиглэлээр хийгдсэн ийм томоохон үнэхээр бодит ажил гэж боддог. Тэгэхээр энэ соён гэгээрүүлэх ажил дээрээ та бүхэн маань бүүр онцгойлон анхаараач, илүү сайн далайц.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайд асуулт асууж, үг хэлье.

О.Алтангэрэл: Би энэ дээр үг хэлчихье. ХЭҮК-оос жил болгон энэ эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг гаргадаг. Харамсалтай нь сүүлийн жилүүдэд энэ илтгэлийн талаар ярих нь их багасаж, ач холбогдол өгөх нь их жоохон багасаж байсан, энэ удаагийн Улсын Их Хурал нэлээн ач холбогдол өгч бид энэ илтгэлийн талаар ярих ёстой, энэ удаад 24 дэх илтгэл гарсан байна. Өнгөрсөн хугацаанд ХЗДХЯ-ны зүгээс хүний эрхтэй холбоотой багц хуулиуд, Хэвлэлийн эрх чөлөө, Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулиудыг боловсруулахдаа Хүний эрхийн Үндэсний Комиссынхоо илтгэлийг нэлээн баримталж, энэ тусгагдсан Улсын Их Хурлаар шийдвэр гаргуулахаар өгсөн санал энэ зүйлүүд дээр нэлээн ажилласан. Тэгэхээр ер нь нийгэм даяараа энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлд нэлээн ач холбогдол өгч ярьж байх ёстой. Энэ нь өөрөө бид нарын хүний эрхийн төлөв байдал, нөхцөлийг сайжруулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ хэрэгжүүлэхэд нэлээн түлхэц болох ийм учиртай юм. Тийм учраас

энэхүү илтгэлийг ингээд хуулийнхаа хугацаанд нэлээн чамбай сайн оруулж ирж байгаа комиссын гишүүддээ талархал илэрхийлье.

Би үг хэлэхийн учир бол Улсын Их Хурлын эрхэм гишүүддээ хандаж яг өнөөдөр энэ илтгэлийг хэлэлцэж байгаа энэ цаг үед хүсэлт тавья гэж бодсон юм. Өнгөрсөн оны төсөв хэлэлцэж байхад бид энэ цагдан хорих байртай холбоотой, баривчлах байртай холбоотой нөхцөл байдлууд дээр ХЗДХ-ийн салбарт орон тооны асуудал байна гээд ингээд учирлаад, тэгээд энэ асуудал дээрээ 50 хувьтай шийдүүлж авсан. Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллагаас энэ баривчлах байрны чиг үүрэг хэрэгжүүлж байгаатай холбогдуулан хэд хэдэн газрын баривчлах байртай холбоотой зүйл барья гэж санал оруулаад 100 хувь хасагдсан. Өнөөдөр яг ингээд илтгэл дээр жишээлбэл орж ирж байгаа нь энэ хэрэг мөрдөгдөж байгаа мөрдөн шалгахтай холбоотой ачааллыг бууруулах шаардлагатай байна. Энэ албан хаагчдын тоог нэмэх шаардлагатай байна гэсэн ингээд ийм утга санаагаар Улсын Их Хурлаас шийдвэр гаргуулахаар өгч байгаа саналууд дотор нь асуудал байгаа юм.

Тэгээд энэ дээр шинжилгээ хийж байгаа, энэ өмгөөлөгчийн ажил үүргийн чиг үүргийн баталгаатай холбоотой, цахим технологи, технологитой холбоотой, нэг мөрдөгч, нэг прокурорт холбогдож байгаа хэргийн энэ ачаалалтай холбоотой гээд өөрсдөө хөрөнгө мөнгө шаардах эдгээр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд хөрөнгө мөнгө шаардах нэлээд олон арга хэмжээнүүд байна. Хүний эрхийг, хүний эрхийн баталгааг хангаж бид хууль тогтоомж боловсруулж, хууль тогтоомжоо баталж, энэ зүйлийг хамгаалахын төлөө бид ажиллах үүрэгтэй хүмүүс. Яамнууд, ХЗДХЯ, харьяа байгууллагууд, бусад байгууллагууд ч гэсэн энэ чиг үүргээ хэрэгжүүлнэ. Гагцхүү материаллаг зүйлсээс хамааралтай, хөрөнгө мөнгөнөөс шаардлагатай зүйлүүд байдаг шүү. Эрхэм гишүүд минь энэ удаагийн илтгэлийг хэлэлцэхдээ аль зүйлүүд дээр нь бид ер нь хөрөнгө санхүү тавих ёстой юм бэ гэдгээ бас нэг хараасай гэж та бүхнийгээ хүсэж байгаа юм. Ирэх жилийн төсөв хэлэлцэх үеэр.

Бид яг энэ комиссынхоо илтгэлд дурдсаны дагуу асуудлаа шийдвэрлэе гээд комиссынхоо илтгэлийг үндэслэл болгоод асуудлууд оруулаад ирнэ. Тэр үед та бүхэн маань хүний эрхийг хангах чиглэлээр комисс маань илтгэл гаргачихсан, үүнийг хэрэгжүүлэх чиглэлээр бид хэлэлцсэн, тодорхой шийдвэр гаргах ёстой гэдгээ ухамсарлаж, энэ салбарт хүний эрхийг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлэх цаашдын төсөл, хөтөлбөрийг дэмжих нь Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг хангахад чухал үүрэгтэй шүү. Мөн өнөөдөр хэлэлцэж байгаа бидний Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн нэмэлт, өөрчлөлт болон хүний эрхийн багц хуулиуд бол энэ илтгэл дээр дурдсан зарим нэг зүйлийг шууд шийдвэрлэхүйц байгаа шүү гэдгийг эрхэм гишүүддээ хандаж хэлье. Баярлалаа та бүхэнд.

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайд үг хэллээ. Ухнаагийн Отгонбаяр гишүүн асуулт асууж, үг хэлье.

У.Отгонбаяр: Та бүгдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл өнөөдөр Улсын Их Хурлаар орж ирж байна. Энэнд манай Их Хурлын гишүүд ач холбогдол өгч, нэлээдгүй санал санаачилгатай байгаад нь их баяртай байгаа. Сүүлийн үед яг ний нуугүй хэлэхэд

энэ хүний эрх, эрх чөлөөний асуудал нэлээдгүй хаягдсан. Энэ илтгэл мөн нэг үеэ бодоход харьцангуй энэ итгэлд ач холбогдол өгдөг болсон байна. Энэ бол маш сайшаалтай. Тэгээд энэхүү илтгэлийг 6 бүлэг сэдвийн хүрээнд бэлтгэсэн байна.

Тэгээд энэнээс аргагүй нэг анхаарал татаж байгаа сэдэв бол энэ цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийлэл гэж. Өнөөдөр бид бүхэн энэ цахим ертөнцөд алхам тутамдаа гэмт хэргийн хохирогч болж байгаа. Тэр дундаа хүүхэд багачууд. Миний өнөөдрийн асуух гэж байгаа асуулт цахим ертөнцөд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн хэдэн хувь нь насанд хүрээгүй бага насны хүүхэд хохирогч болж байна гэж 1 дүгээр асуулт, хэдэн хувь нь? Үүнээс, 2 дахь асуулт үүнээс хэдэн хувь нь шүүхээр шийдэгдэж байна гэж асуумаар байна? 3 дахь асуудал соён гэгээрүүлэх чиглэлээр нарийн төлөвлөгөө гарсан байдаг байх. Тэгээд энэ соён гэгээрүүлэх төлөвлөгөөний яг хэдэн хувь нь энэ цахим ертөнцөд үйлдэгдэж байгаа, тэр дундаа бага насны хүүхэд рүү чиглэсэн ажил байдаг вэ гэсэн эдгээр 3 асуултад тодорхой хариулт өгөөч?

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Ж.Хунан: Отгонбаяр гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр МУИС-ийн Жендер судлалын төвөөс судалгаа хийсэн байдаг юм байна лээ. Энэ судалгаанд нийт 6-12 дугаар ангийн 18044 сурагчдыг хамруулсан. Эдгээрээс сурагчдаас 9,9 хувь нь буюу 1786 хүүхэд садар самуун зураг бичлэг илгээх үйлдлийн хохирогч болсон гэж, 6,8 хувь нь 1226 хүүхэд бэлгийн сэдлээр хүүхэдтэй холбоо тогтоох энэ үйлдлийн хохирогч болсон, 5,9 хувь буюу 1064 хүүхэд секс илэрхийлэл бүхий дүрс бичлэг хийх, түгээх энэ үйлдлийн хохирогч болсон, 5,5 хувь нь 900 хувь буюу 992 хүүхэд бэлгийн амьдрал, бэлгийн зан үйлээр шүүмжлэх, доромжлох ийм үйлдлийн хохирогч болсон, 5,4 хувь нь 900 хувь буюу 974 хүүхэд бэлгийн сэдлээр сүрдүүлэх ийм үйлдлийн хохирогч болсон, 5,4 хувь буюу 974 хүүхэд бэлгийн дур таашаал авах зорилгоор зураг авах, бичлэг хийх хүчирхийлэлд өртсөн гэдэг ийм хариултыг өгсөн.

Тэгэхээр эдгээр хүүхдүүдийн энэ өртсөн байдал, хохирсон байдлыг шалгасан эсэх нь тодорхойгүй. Өөрөөр хэлбэл эдгээр тэр хүүхдүүд өөрсдөө гомдол гаргаж байгаагүй гэсэн үг, гаргасан байхыг үгүйсгэхгүй. Тэгэхдээ ямар ч байсан 12 наснаасаа наснаас авхуулаад хүүхдүүд бол хүүхэд багачууд маань энэ хүчирхийлэлд өртөх энэ явдал гарчихсан гараад эхэлчихсэн явчихсан байна гэсэн үг. Тэгэхээр энийг бид үндэслэж, энэ бэлгийн боловсролд нь өөрийгөө болон бусдыг хамгаалах энэ урьдчилан сэргийлэх чадавх мэдлэгийг олгох хэрэгцээ шаардлага байна, олгох шаардлагатай гэж харж байгаа.

Д.Амарбаясгалан: Ухнаагийн Отгонбаяр гишүүн тодруулж асууя.

У.Отгонбаяр: Сая энэ тоо баримтууд маш их зүйлийг хэлж байна шүү дээ. Энэ маш эмгэнэл, маш том эмгэнэл. Тийм учраас бид бүхэн цаашдаа энэ чиглэл рүү нэлээн анхаарал хандуулах зайлшгүй шаардлага байгааг энэ тоо баримтууд хэлж байна гэж үзэж байна. Энэ илтгэлд би нэг хэсгийг энд бүүр зориуд уншиж өгье гэж бодож байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн механизмаас цахим технологи ашиглан жендерт суурилсан хүчирхийллийн хор уршиг өсөн нэмэгдэж байгаад онцгой анхаарал хандуулж, улс орнуудыг хууль эрх зүйн орчноо сайжруулах, соён гэгээрүүлэх арга хэмжээгээ өргөжүүлэх, хохирогчид

үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэхийг зөвлөж байна гэж НҮБ-аас ийм зөвлөмж өгсөн байгаа юм. Тийм учраас энэ илтгэлийн ар дээр Улсын Их Хурлаас.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлье.

П.Сайнзориг: Сайн байцгаана уу, бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. ХЭҮК-оос Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дүгээр илтгэлийг оруулж ирсэн 6 бүлэг асуудлуудыг нэлээн ултай суурьтай л дүгнэж цаашид, Улсын Их Хурал, ЗГ болон төрийн бүх түвшинд ямар арга хэмжээ авах ёстой вэ, олон нийт болон хувийн хэвшилтэйгээ хэрхэн яаж ажиллах вэ гэдэг зүйлийг уг нь тодорхой л биччихсэн байна. Тэгээд хуучин Хүний эрхийн Үндэсний Комиссын тайланг ХЗБХ-н дээр халти сонсчихоод, хаячихдаг л байсныг Улсын Их Хурлаар хэлэлцдэг болсон. Энэ 3 дахь удаагийнх уу, 2 дахь удаагийнх л байгаа.

Тэгэхээр энэ дээрээс бид хэд яг л дэвшлийг гаргамаар байна. Тийм учраас би гишүүддээ уриалж өнөөдөр улсын төсөв хэлэлцэх үе шат буюу боловсруулах шатдаа явж байгаа энэ цаг үе дээр энэ орж ирсэн тайланг хэлэлцээд, холбогдох Улсын Их Хурлын тогтоолыг энэ хүний эрхийн 24 дүгээр илтгэлтэй холбоотойгоор Улсын Их Хурлын холбогдох шийдвэрийг гаргаж, ЗГ-т тодорхой асуудлуудаар үүрэг чиглэлийг өгөх ёстой гэж бодож байгаа юм. Нэг яриад өнгөрчихдөг биш, асуудлуудыг нэг шийдэх эрмэлзэл байгаасай гэдэг ийм хүсэл эрмэлзэл байна. Түрүүн Алтангэрэл сайд гишүүддээ уриалга хүргээд байх шиг байна. Миний санаа төстэй. Тэгэхээр энэ төсөв боловсруулж байх үе шат дээр бид яг энэ дээрээс асуудлуудыг эрэмбэлээд, аль асуудлаа шийдэх вэ гэдэг зүйлийг одоо бас ярилцаад, Хурлын даргаас яг энэ гишүүдийн асуулт асуусны дараагаар тодорхой Байнгын хороонд уг асуудлаар Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг оруулж ирж арга хэмжээ авах ёстой гэсэн ийм зарчмын гэх үү саналтай байгааг та анхаарч үзээч гэж 1 дүгээрт хүсэж байгаа юм.

Тэгээд энэ орж ирж байгаа илтгэлийн хамгийн нэг чухал сэдэв нь сонгох, сонгодог эрхийн талаар орж ирсэн. Тэгээд энэ зөвлөмж дээрээ биччихсэн байна л даа. Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын хүний эрхийн гэрээ конвенцод заасан сонгуулийн үндсэн зарчимд нийцүүлэн сонгуулийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийн зөрчил, хийдлийг арилгах, хууль тогтоомжийн үр дагаврыг үнэлж, үр дүнд нь тулгуурласан процедур, механизм, хугацаа, хариуцлагын талаар хууль тогтоомжийг зохицуулалтыг өөрчлөөрэй гэдэг ийм зөвлөмжийг өгчихсөн байна. Би зүгээр нэг том агуулгаар нь л уншихлаа. Тэгээд сүүлийн үед Цэц дээр сонгуулийн хууль тогтоомжийн талаарх маргаан нэлээн ихсэж байна. Бараг 5, 6 маргаан явж байна. Сонгуулийн хуулийг дагаад орсон Зөрчлийн хууль дээр хүртэл маргаан үүсгэчихсэн байна. Ингээд бодохоор энэ 28 оноос буюу өмнө энэ сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох цаг үе нь энэ жилийн хувьд л байна гэж харж байгаа юм. Тэгэхээр энийгээ бүүр нэг тодорхой болгох асуудлыг Улсын Их Хурлын гишүүддээ би уриалмаар байгаа юм. Ер нь нэг ажлын хэсэг гаргаад ултай суурьтай үзчихмээр байна. Тэгээд энэ зүйлээ хийхгүй бол болохгүй гэдэг зүйл байгаа юм.

2 дугаарт миний зүгээр энэ сэдвийн хүрээнд нэг эмзэглээд байгаа зүйл гэхээр Үндсэн хуулийн 21 дүгээр зүйл дээр байгаа. 21.4 дээр ийм зүйл байгаа л даа. Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. Улсын Их Хурлын

ээлжит сонгууль явуулахын өмнө нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэхийхсэн. Гэтэл энэ цаг хугацааны нэг жилийн энэ хориглолтыг хязгаарлалтыг тавьчхаад байгаа мөртөө Цэцэд гомдол гаргах, Цэцэд яг энэ сонгуулийн хууль тогтоомжтой холбоотой маргааны шийдвэрлэхэд цаг хугацааны хязгаарлалт байхгүй. Сонгуулийн жил эхлэхээс эхэлсэн ч бай, жил сонгууль болох тэр жилдээ багтааж ямар ч маргааныг шийдэж болно. Тэгэхээр энэ зүйлүүд юу аваачих гээд байна гэхээр сонгуулийн хууль тогтоомж нь Үндсэн хууль зөрчсөн хуулиараа сонгуулиа хийх үү, эсвэл тодорхой сонгуулийн хууль тогтоомжоо сайжруулахын тулд дахиж нэг жилээр сонгууль явуулахыг хойшлуулах уу гэдэг том үр дагавар луу цаашдаа явуулах ийм нөхцөл байдлыг үүсгэж байгаа юм. Тэгэхээр энэ 19 оны өөрчлөлтийн үр дагаврыг цаашаа дэвэргэхээс нь өмнө бид.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сайнзориг гишүүнд 1 минут нэмж өгье.

П.Сайнзориг: Үр дагаврыг улам томрохоос нь өмнө, магадгүй энэ Үндсэн хууль зөрчсөн сонгуулийн хууль тогтоомжоор сонгуулиа явуулах юм бол энэ ард нийт чинь гудамжиндаа гарна. Эсвэл энэ хууль тогтоомжоо засчхаад сонгуулиа явъя гэвэл 4 жилийн парламент чинь 5 жил ч болж сунаж ажиллах ийм нөхцөл байдал руу орохоор байна шүү. Тэгэхээр энэ асуудлуудыг бага дээр нь засах энэ нөхцөл байдлуудыг Улсын Их Хурлын гишүүд маань анхаараач. Хурлын дарга анхаарч, энэ хууль тогтоомж Үндсэн хуулийн энэ заалт ч гэсэн өөрөө их үр дагавартай учраас энийг анхаарахаас өөр аргагүй гэдэг зүйлийг би хэлмээр байгаа юм. Тэгээд ийм санаатай үйлдлийг Цэц дээр ч гаргахыг үгүйсгэхгүй. Тийм учраас энэ нөхцөл байдлуудыг цаг хугацаагаар хязгаарлах биш, хууль батлах квотыг ойлгомжтой болгож, магадгүй энэ Үндсэн хуулийн шинжтэй органик хуулиудыг батлах асуудлыг 66 хувиар баталдаг энэ эрх зүйн горим руугаа орохгүй бол ингэж consensus-т хүрвэл энэ цаг хугацааны хязгаарлалт байх шаардлагагүй. Тэгэхээр энэ зүйлүүдээ том зургаараа бид анхаарах ёстой байна шүү гэдэг зүйлийг би энэ илтгэлийг хэлэлцэж байх явцад.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууж, үг хэлье.

О.Батнайрамдал: Баярлалаа. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дүгээр илтгэлийг талархалтай хүлээж авч байна. 6 бүлгээс бүрдсэн энэ илтгэлийн маш сонирхолтой, ирээдүйд нэлээн эрсдэл дагуулахаар нэг хэсэг бол яалт ч үгүй хүний эрх, цахим технологи, тэр тундаа хиймэл оюун. Яагаад гэхлээр хиймэл оюун бидний ирээдүйг бидний төсөөлөхгүйгээр илүү өөрчлөх нь ойлгомжтой болчихлоо. Интернэт жишээлбэл бидний амьдралд нэвтэрснээрээ анх бидний төсөөлж байснаас илүү бидний амьдралыг тэр чигээр нь орвонгоор нь өөрчилсөн байдаг. Тэгэхээр яг ийм цаг мөчид яг бид бүхэн амьдарч байгаа юм. Тэгэхээр яг хиймэл оюун өнөөдөр бид магадгүй Америк, Хятадын хооронд явж байгаа нэг өрсөлдөөн гэж харж байгаа боловч яг үнэндээ бидний амьдралд гар утсаар дамжуулаад, бидний гар утас дээр дамжуулж байгаа аппликэйшнээр дамжуулаад маш олон арр зөндөө зүйлүүд дээр хиймэл оюун аль түрүүн ашиглагдаад эхэлчихсэн гэсэн үг. Тэгэхээр нэг ёсондоо бидний амьдралд аль түрүүн нөлөөлөөд эхэлчихсэн.

Жишээлбэл бид нарын хамгийн өргөн хэрэглэгддэг жишээлбэл chatGPT байна. Ялангуяа залуучууд бараг ашигладаггүй залуучууд байхгүй болчихсон байна лээ. Тэгээд энэ Стэнфордын их сургуулиас 2023 онд гаргасан Стэнфордын хүн төвтэй хиймэл оюуны судалгааны төв гэж байдаг. Тэгээд энэ төвийн судалгаан дээр нэг тийм ноцтой зүйл гарч ирсэн юм л даа. Тэр нь юу гэхээрээ ChatGPT-г ашиглаад гарч байгаа үр дүн нь улс төрийн чиг баримжааны хувьд жишээлбэл pro democratic буюу илүү Ардчилсан намын үзэл баримтлалыг дэмжсэн хариулт илүү ...Republican буюу Бүгд найрамдах намын жишээлбэл илүү сөрөг дүгнэлтүүдийг автоматаар өгдөг ийм дүгнэлт гарч байгаа юм. Тэгэхээр нэг ёсондоо chatGPT-ээс гарч байгаа тэр их мэдээлэл, өгч байгаа мэдээлэл улс төрийн чиг баримжаанд ингээд бидний шууд бусаар аль түрүүн нөлөөлсөн ийм судалгааны үр дүн гарсан байгаа юм л даа.

Тэгэхээр хиймэл оюун өөрөө ингээд цаашаагаа бидний амьдралд илүү нэвт шингээд, дэлгэрээд ирэх тусам хүний эрхтэй холбоотой зөндөө асуудлууд ингээд хөндөгдөж эхэлнэ л дээ. Тэгэхээр зөвхөн хүний эрхээс гадна ёс зүйн ethics буюу ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой, цаашдаа ер нь ирээдүйд хүн төрөлхтөн ч гэсэн д энэ хиймэл оюуныг ашиглаж чадаж байгаа, ашиглахгүй байгаа хоёрын хооронд маш том ялгаа, цахим хуваагдал, ялгавар ингээд гарч ирэх нь ойлгомжтой болчихож байгаа юм. Тэгэхээр энэ нь хүний эрх талаас нь ингээд аваад үзвэл ер нь одоо ч гэсэн бид магадгүй эрсдэлээ бүрэн ойлгохгүй хэмжээнд байгаа юм л даа. Тэгэхээр та бүхний тайлан дээр ч гэсэн нэлээн дэлгэрэнгүй орсон байна л даа. Ер нь олон улсын жишгийг аваад үзвэл илүү хуульчилсан гэхээсээ илүүтэйгээр хиймэл оюуны хүний эрхийн эрсдэлийг бодлогын эрх зүйн зохицуулалт дээр илүү зөвлөмж, удирдамж шинж чанартайгаар зохицуулаад явж байгаа.

Энийг бид харахдаа ч гэсэн ёс зүйн хөгжил талаасаа нэг талаасаа үүсэх эрсдэл, нөгөө талаасаа инновацыг хэтэрхий хязгаарлах вий, хориглож хязгаарлах вий гэсэн 2 балансыг ингээд барьж буцаад хиймэл оюуныг илүү оновчтойгоор ашиглах боломж нь бүрдэнэ л дээ. Тэгэхээр Монгол Улсын хувьд хиймэл оюуны үндэсний стратегия удахгүй гаргана гэж ойлгож байгаа. Ер нь дэлхийн 70 гаруй орон хиймэл оюуны бэлэн байдал үндэсний стратегия тодорхойлсноороо учирч болох эрсдэлдээ авч явах арга хэмжээнүүдээ ойлгомжтой болгосон байгаа юм. Тэгэхээр манай улсын хувьд ч гэсэн энэ үндэсний стратегия яаралтай тодорхойлж, ер нь гарч болох эрсдэл дээр ямар арга хэмжээ авах вэ гэдгээ бусад улсын жишгээс тодорхой авч.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Отгоншарын Батнайрамдал гишүүнд нэмж 1 минут өгье.

О.Батнайрамдал: Тэгэхээр хиймэл оюуны үндэсний стратеги дээрээ энэ бүхнийгээ бид нэг ойлгомжтой заавал болгох ёстой байгаа юм. Дэлхийн бараг 70, 80 орон өөрсдийнхөө үндэсний стратегия учирч болох эрсдэлүүдийн хүрээнд цар хүрээгээ бүгдээрээ тодорхойлоод явж байгаа. Тэгэхээр манай улсын хувьд ч гэсэн яг энэ нэг ёсондоо дутагдалтай хэсэг нь яалт ч үгүй мөн. Хиймэл оюуны бэлэн байдлын үнэлгээгээр ч гэсэн 198 орноос Монгол санаж байгаагаар бол хамгийн сүүлийн байдлаар 98-д жагссан байгаа юм. Тэгэхээр энийгээ ч гэсэн урагшлуулах боломж нөхцөл нь буцаад хүний эрх дээр гарч ирэх эрсдэлүүдийг бид хэрхэн авч үзэх вэ, ямар зөвлөмж, ямар хууль тогтоомж гаргах вэ гэдэгтэй шууд уялдана гэсэн үг. Тэгэхээр энийг бид аль болох олон улсаас хоцрохгүй хурдан гаргах тусмаа учирч болох эрсдэлийг бид ардаас нь хөөж биш, урдаас нь харж бусад орны

жишгийг хөрсөн дээрээ буулгах боломж нөхцөл нь бүрдэнэ гэж харж байгаа. Тэгэхээр та бүхний энэ тайлан дээр нэлээн дэлгэрэнгүй туссанд талархалтай хандаж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууж, үг хэлье.

С.Эрдэнэбат: Хүний эрхийн Комиссын 24 дүгээрх хүний эрхийн илтгэл тайланг Их Хурлаар хэлэлцдэг болсон нь маш өгөөжтэй юм. Тэгээд өнөөдөр олон улсын ажил хөдөлмөр эрхлэгчдийн эрхийн өдөр. Үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудаас гадаа жагсаал цуглаан хийж, 10 зүйл шаардлагыг Улсын Их Хурал, Засгийн газарт ингээд өгсөн байна. Энэ нь өнөөдрийн хүний эрхийн илтгэлтэй холбоотойгоор холбож ярихад сонгуулийн үед амласан амлалтууд маань бүгд байж байна энд. Цалин хөлс нэмэгдүүлэх, орон сууцыг хангах, эдийн засгийн инфляцыг тогтворжуулах, эрүүл мэндийн даатгал, банкны зээлийн хүү гэх мэтчилэн. Тэгэхээр энэ сонгуулийн үеэр энэ улс төрийн намуудын бүгд л амлалтад нь орсон. Үүнд улс төрийн намуудын мөрийн хөтөлбөртөө хандаж байгаа байдал, нөгөө талаараа энэ сонгуулийн хуультай холбоотойгоор нэлээн олон саналууд тавьсан байна. Өнгөц харахад яах вэ сонгох, сонгогдох эрх гэж харж байгаа боловч юу руу түлхэх зүйл рүү нөгөө талд нь өнцгөөс нь харсан тохиолдолд илүү мөнгө хөрөнгөтэй гэдэг юм уу, илүү олонд танигдсан гэдэг юм уу иймэрхүү сонгуулийн ганцаарчилсан тоглолт хийх ийм боломж бололцоо руу нөгөө тал өнцгөөс нь харвал шийдэж болзошгүй тийм зүйлүүдийг дурдсан байна гэдэг зүйлийг би онцолж хэлмээр байна.

Хүний эрхийг хамгаалагчийг хамгаалах сэтгүүлч, өмгөөлөгч 2-ыг тодорхой хөндсөн байна. Зөв асуудал. Хүний эрхийг хамгаалагчийг хамгаалах тухай хууль гээд батлагдаад удаагүй байгаа. Яг энэ хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажиллаж байгаа хүмүүсийн эрх ашигтай холбоотой, ноцтой зөрчилтэй холбоотой, гүтгэж доромжлогдож байгаа, эрсдэлд өртөж байгаа асуудлаар Хүний эрхийн Комисс маань нөгөө Хянан шалгах хороо маань, Эрүүдэн шүүх хороо маань хэчнээн хэрэг авч хэлэлцэв? Тухайлбал энэ улс төрийн намуудын хамтарсан ЗГ-аас хойш надад олон санал гомдол ирж байгаа. Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын сонгуульт ажилтнууд ажлаасаа халуулахгүйн тулд олон хүний өргөдөл гомдлыг бариад эрх мэдэлтэй томилогдож очсон хүмүүстэй маргаан зарга хийдэг. Зөрүүлээд тэр хүмүүсийг элдэв янзын дарамтад өртүүлэх гэдэг юм уу ийм зүйлүүд гарсаар байна. Тэгэхээр энэ тал дээр тэр хороо маань ямар, ямар зүйлүүд хэлэлцсэн юм бэ гэдгийг 1 дүгээрт асуумаар байна.

Мөн залуучуудын асуудал дээр энэ хүүхдүүдийн ноцтой тоо харагдаж байна. Энэ 50 хувь нь ямар нэгэн байдлаар хүүхдүүдээс санал асуулга асуухад 50 хувь нь ямар нэгэн байдлаар сошиалаар доромжлуулсан, гүтгүүлсэн ийм байдалд хүчирхийлэлд автсан, 5 хувь нь бүүр бэлгийн хүчирхийлэлд сошиал бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна гэж байна. Тэгэхээр өнөөдөр хүүхэд болгон фэйсбүүкийн хаягтай. Уг нь насанд хүрээгүй хүүхдүүд фэйсбүүкийн хаяг хийх нь хуулиараа хориотой. Гэхдээ ямар нэгэн байдлаар хүүхдүүд манай хүүхдүүд маань бүгд нээлттэй байж байдаг. Тэгэхээр энийг түүвэр судалгаагаар ингээд гарч байгаа юм бол цаанаа нэлээн том асуудал дагуулах юм байна л даа. Томчууд бидэнтэй зэрэгцэж очоод 10, 11-тэй, 9, 10-тай хүүхдүүд маань ингээд фэйсбүүкээр явж байгаа олон янзын хэрүүл тэмцэл, бие биеэ доромжилсон, гүтгэсэн, тэгээд нийгэм чинь нэг нэгнээ тийм үзэн ядсан, ирээдүй хойч үедээ үлгэр дуурайлал муу үлгэр

дуурайлал болох юм бидний нүдэн дээр фэйсбүүк нээхэд л харагдаж байна шүү дээ. Тэгээд энэ тал дээр тодорхой хязгаарлах ийм сошиалыг хөхиүлэн дэмжсэн, оролцсон энэ зүйл дээр энэ дээр Их Хуралд тодорхой арга хэмжээ авах хэрэгтэй гэж миний хувьд харж байна.

Дараагийнх нь сэтгүүлчийн редакцын хараат бус байдал гэдэг дээр тодорхой тавьсан байна. Хэвлэл мэдээллийн олон нийтийн хамтын тийм хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг нэлээн дэмжих хэрэгтэй гэдэг дээр би санал нэг байна. Тухайлбал Монголын олон нийтийн гэж байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслүүд маань яг бүрэн үүргээ гүйцэт, нэмэлт.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Эрдэнэбат гишүүнд нэмж 1 минут өгье.

С.Эрдэнэбат: Нэмэлт үүргээ гүйцэтгэж чадаж байна уу, үгүй байна уу дээр хүртэл дүгнэлт тавьсан байна л даа. Би энэнтэй тодорхой хэмжээгээр санал нэг байна. Дараагийн нэг асуудал энэ сошиал хүчирхийлэл гэж байгаа. Ялангуяа ажлын байран дээр хүмүүсийг шууд бичлэг хийгээд нийтэд тавьчихдаг гүтгээд. Эмнэлэгт очоод нэг сувилагчийг тавьчихдаг хүн алчхаж гэнэ гээд л тавьчихдаг. Тэр хүн бараг өөрөө амиа хорлох тухай хүртэл оролдож үзсэн байгаа байхгүй юу. Үнэн худал нь мэдэгдэхгүй. 1 багшийг ингээд хүүхдийг гэмтээсэн зодсон барьсан гээд тавьчихдаг. Энэ нь өөрөө ажлаас халшрах хам шинж гэдэг өвчин рүү аягүй их түлхэж байгаа. Тийм учраас энэ асуудал дээр тодорхой хуулийн зохицуулалтыг тавихгүй бол ялангуяа үйлчлүүлж байгаа ажил хөдөлмөр эрхэлж байгаа залуучуудыг ийм олон нийттэй харьцах ийм ажлаас халшрах ийм юм руу нэлээн түлхэж байгаа юм. Энэ дээр маш тодорхой үнэлэлт дүгнэлт хийж, бид хариуцлагыг нь сайжруулах хэрэгтэй гэдгийг хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр хүний эрхийн төлөв байдлын 24 дэх илтгэлийг ХЭҮК-оос судалгаа, тайлан, хяналт шинжилгээ, үнэлгээ, гомдол мэдээлэл, дүгнэлтэд тулгуурлаад 6 үндсэн бүлэг дээр оруулж ирж байна. Тэгээд би бодоод байгаа юм л даа. Аливаа зүйл ухаалаг хил хязгаартай байх тухай л ойлголт ер нь. Хүний эрхийг хангах гэдэг юм уу, хүний эрх, эрх чөлөөг эдлүүлэх чиглэл дээр төр хийгээд төрийн зохих эрх мэдэлтнүүд хүлээсэн үүргээ хэрхэн хангаж байгаа вэ гэдэг асуудал байгаа юм. Энийг бид зохицуулж болно. Тийм учраас танайх магадгүй энэ илтгэл дотроо тэр тодорхой институтүүдэд зөвлөмж өгөх эрхтэй шүү дээ. Их Хуралд нь, ЗГ-т нь, тэр хууль хяналтын байгууллагуудад нь зөвлөмжөө тэгж гаргасан нь дээр байх гэж би бол энэ талаас нь хараад байна. Нэгэнт ямар илтгэлийг дагуулаад гарах шийдлээ тодорхойлоход ямарваа нэгэн зөрчил үүсэхгүй шүү дээ энэ чинь нэгэнтээ судалгаа бүх юм нь хийгдээд, тайлан нь гараад ирж байгаа учраас. Ингэвэл хэдүүлээ амь орох нь дээр юм уу гэж. Энэ талаасаа нэг хармаар байна гэж.

2 дахь зүйл энэ хүнээр хүн хийдэг, хүн төлөвшүүлдэг тэр өвгөдийнхөө өв соёлыг энэ цагийн эрх зүйтэйгээ хүний эрхтэйгээ яаж холбох юм бэ? Ер нь магадгүй энэ чинь их дутчихсан байж мэднэ шүү. Хүүхдийн хүмүүжил төлөвшлийн тухай ярихаар зэрэг манай боловсролын салбарынхан юу гэж байсан бэ гэхээр зэрэг сургалтын хөтөлбөрийн агуулгад байгаа юм гэж ярьцгаагаад, хүүхдийн хүмүүжил төлөвшлийн асуудлыг үндсэндээ орхигдуулсан байхгүй юу. Тэр бүхэл

бүтэн үе өнөөдөр нэлээн тийм нас бие гүйцэж, амьдрал ахуй руу хөл тавьж орж ирж байгаа. Энийг дагаад байдал тийм амаргүй байж мэднэ шүү. Тийм учраас цаашид энэ юмнуудаа нэлээн сайн ул суурьтай дүн шинжилгээ хийж, энэ чиглэл дээр үнэхээрийн алдаа бидэнд байгаа юм бол засах чиглэлээр нь юмаа хийх ёстой. Би энэ талаас нь л бодоод байдаг.

Ер нь өнөөдрийн хүүхдүүд ирээдүйн эцэг, эхчүүд шүү дээ. Тэгээд бид хэд чинь заримдаа учиргүй нэг талдаа савах юм байна шүү дээ. Төрүүлээд өсгөчихсөн эцэг, эхээс нь хүүхдийг хамгаалах гэж оролддог эд нар юмнууд хамаагүй их гаргаж ирэх юм. Зарим нь мэдээлэл олж авах эрхийн тухай ярих юм, зарим нь мэдээлэл түгээх эрхийн тухай ярих юм. Үгүй ээ тэр дотор явж байгаа мэдээлэл дотор чинь яг нарийндаа хүний төлөвшилтэй холбоотой мэдээлэл байгаа юм уу? Магадгүй хүний оюун санааг гэмтээж мэдэхээр мэдээлэл нь давамгайлчихаад яваад байгаа байхгүй юу. Тэгвэл энийгээ засах ёстой шүү дээ. Энэ өргөн нэвтрүүлэг гэдэг юм уу, энэ олон сувгуудаа хар юу явж байна тэнд. Гаднын улс орнуудын бэлтгэчихсэн контентууд мэдээлэл урсаж байна шүү дээ. Тэгэхээр бид туурга тусгаар үндэстэн байгаа өөрсдийнхөө иргэдийг бэлдэнэ, төлөвшүүлнэ, эх орныхоо төлөө хөгжил цэцэглэлтэд нь хувь нэмрийг нь оруулна гэж бодож байгаа бол ёстой өнөө кодлолт гэдэг юмаа ярих ёстой. Монгол хүн гэж ийм хүн байх ёстой. Энэ хүнийг төлөвшүүлэхэд боловсролын сургалтын хөтөлбөр талдаа ч ийм юм байх ёстой, мэдээллийн технологи талдаа явах урсгалынх нь контент ч ийм юм байх ёстой, өрх гэр талдаа ч гэсэн тэр хүнийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батжаргал гишүүнд 1 минут нэмж өгье.

Ж.Батжаргал: Ойртуулдаг юм нь ийм л юм байх ёстой гэдэг талаасаа харах ёстой юм. Тэрнээс ярьснаараа тийм хүн болчихдог юм байхгүй шүү дээ яг үнэнийг хэлэхэд. Тэгэхээр энэ талаасаа би бол судалгааны юмыг ер нь нэг жоохон өргөжүүлмээр байна. Би энэ талаас нь хараад байгаа.

3 дахь миний хэлчихмээр байгаа санаа. Хууль тогтоомжууд элдэв бусын юмнуудыг сүрхий засварлам өнгөтэй нэг тийм урсгал руу орчихлоо хэдүүлээ. Энэ эрх зүйт төрийг төлөвшүүлээд, бас нийгмээрээ нэг тийм тогтчихсон ойлголт юм руу явчихсан байхгүй юу. Гэтэл өнөөхийг нь эвдээд бужигнуулаад эхэллээ. Дам дамаа энэ сонгуультай холбоотой юман дээр их гардаг болчихлоо. Сонгууль гэдэг хэдэн баримталдаг том зарчим бий, тэрийг дагах ёстой. Дагуулаад улс үндэстэн өөрийнхөө онцлог тэр юман дээрээ тулгуурлаж түүнийгээ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууж, үг хэлье.

Х.Булгантуяа: Энэ удаагийн тайлан мэдээлэлд хүний эрхийн тайлан мэдээлэл дараа дараагийн хуулиудыг засах, хэрэгжилтийг сайжруулахад нэн чухал байдаг. Би үүн дээр 1 асуудлыг онцлох гэсэн юм. Энэ хүүхдийн бэлгийн хүчирхийллийн асуудлыг. Энэ та бүгдийн тайлан дээр ингэж гарсан байна ШШГБ-аас ирүүлсэн мэдээллээр сүүлийн 5 жилийн хугацаанд бага насны хүүхдэд бэлгийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэгтэй холбогдон 902 хүн ял шийтгүүлсэн, 152 хоригдол хугацаанаасаа өмнө суллагдсан, 7 хоригдол өвчний улмаас ялаас чөлөөлөгдсөн, 7 хоригдлыг Улсын дээд шүүхээс цагаатгасан гэж. Энэ яг үнэнийг хэлэхэд энэ үнэхээр манай хуулийн тогтолцоо хүний эрхийн мэдрэмжгүй

байгаагийн нэг юу. Хууль зүйн сайд Энхбаяр байхдаа ийм хэдэн хуулийн өөрчлөлтүүдийг хийсэн. Та бүхэн сайн мэдэж байгаа байх. Хүүхдийн эсрэг гэмт хэрэгт ноогдуулах ялыг чангатгах багц хуулийг өргөн барьсан. Энэ хуулиар хүүхдийг хүчиндэх, бэлгийн мөлжлөг, хүүхдийн наймааны ялын хугацааг уртасгасан, тэнсэнг байхгүй болгосон, өршөөлгүй болгосон, хорих хугацаанаас нь өмнө суллахгүй болгосон, хүчээр бэлгийн харьцаанд орох хэргийг хүнд гэмт хэрэгт тооцдог болсон. Тэгэхээр энэ нь хэдэн оны, энэ 24 онд 2, 3 хүнийг өршөөлд хамруулсан гэсэн байна. Тэгэхээр энэ энэ хуультай чинь зөрчилдөөд байгаа юм биш үү 1 дүгээр асуулт?

2 дугаарт нь бид хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа бэлгийн гэмт хэрэгтэй уялдуулан бэлгийн гэмт, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдсэн хүмүүсийг бүртгэлжүүлээд, суллагдсаны дараа ч гэсэндээ энэ бол Америкт байдаг шүү дээ. Бүртгэлжүүлээд эсхүл бүүр тэрнийг олон нийтэд мэдээлдэг Америкт бол. Миний шууд ингээд шуудангийнхаа хаягийг оруулахад миний эргэн тойронд бэлгийн хүчирхийлэл үйлдээд ял эдэлсэн хүмүүс хаана, хаана оршин суудаг вэ гээд хаягаа тэр битгий хэл бүртгүүлсэн байдаг. Олон нийтэд мэдээлдэггүй юм гэхэд ядаж хүүхэд хамгааллын тогтолцооны ажилтнуудад үүнийг мэдээлдэг болгоё гэсэн энэ хуулийн хэрэгжилт нь одоо сайд нь байхгүй байгаад байх юм Улсын Их Хурлын даргаа, уг нь хүүхдийн асуудал хариуцсан сайд ч гэсэн сууж баймаар байх юм. Тэгээд манай ХЭҮК-оос л асуухаас даа. Хүний эрхийн Үндэсний Комиссынхон маань энэ хуулийн хэрэгжилт юу болсон бэ?

Дээрээс нь нэмээд бид Шүүх байгуулах тухай хууль дээр Энхбаяр сайд энэ гэр бүлийн шүүхтэй болъё. Гэр бүлийн шүүхийн асуудлыг энэ гэр бүл, хүүхдийн шүүхийг Монгол Улсад анх удаа байгуулъя. 2026 оны 1 дүгээр сарын 1-нээс эхэлж ажиллуулна гэсэн. Энийг бол бид маш зөв гэж бодож байгаа. Энэ тэгвэл бараг анхан шат дээр, давах дээр ч гэсэндээ ирэх бараг 40 хувийн ачааллыг бууруулна. Тусгайлсан хүүхэд хамгааллын өрөөтэй, тогтолцоотой, үүнд ажилладаг бид ажилтнуудтай болно гэсэн үг. Үүний бэлтгэл ажлыг та бүхэн харж үзэв үү ер нь ямархуу нөхцөл байдалтай байна вэ? 25 он дундаа бараг орчихлоо.

Дараачийн асуудал нь энэ Хүүхэд хамгааллын тухай хуулиар бид анх удаа цахим орчин дахь хүүхдийн эрхийг хуульчилсан, хүүхдийн үл хайхралтыг хуульчилсан, дээрээс нь нэмээд уг нь энэ нэг хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой бид процесс дээр хүүхэд хамгааллын асуудлыг шинэ хуулиар нэлээдгүй хуульчилсан. Гэтэл холбогдох журмыг нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Улсын ерөнхий прокурор, Шүүхийн ерөнхий зөвлөл хамтран батална гэсэн одоо хүртэл батлаагүй байна. Энэ бол ингээд л хууль хэрэгждэггүй байгаагийн том тод жишээ. Харин эсрэгээрээ анхан шатан дээр ажилладаг нийтдээ 833 хүүхэд хүн нийгмийн ажилтнуудаа авах ажлаа бол хийчихсэн юм шиг байна. Төсвөө бол нэмэгдүүлсэн юм шиг байна. Ингээд нөгөө хууль батлахаар иргэдийн эрхийг хамгаалах юм нь явахгүй, бүтэц, орон тоогоо нэмэх ажил нь түрүүлж яваад байдгийн нэг том жишээ энэ болчихоод байгаа юм л даа. Дээрээс нь нэмээд, 1 минутаа нэмээд авчихъя Их Хурлын дарга.

Дээрээс нь нэмээд уг нь энэ хүүхдийн эрх зөрчигдөж байгаа гол газар нь 70 хувь нь гэр орондоо асран хамгаалагдаж, аюулгүй байдал нь хамгаалах ёстой гэр орондоо байгаад байна. Үүний хойно дандаа л архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ голцуу байгаад байна гээд. Бид уг нь Хүүхэд хамгааллын хууль

дээр та хүүхэдтэй айлд архи, согтууруулах ундаа хэрэглээд, дараа нь хүүхдийн эрх зөрчигдвөл хүүхдийн эрх зөрчигдөх нөхцөл байдал үүсгэсэн гээд Зөрчлийн хуулиар шийтгэхээр хуульчилж өгсөн. Тэгсэн чинь энэ хууль 9 сарын 1-нээс хэрэгжиж эхлэхэд ерөөсөө сошиал даяар Булгантуяа архи уувал гэртээ харьж болохгүй гэдэг хууль баталчихлаа гэж баахан сэвсэн.

Гэтэл уг нь хүүхдийн эрхийг хамгаалах ёстой байгууллагууд маань орон тоон дээрээ, төсөв дээрээ санаа зовох биш, энэ хуулийнхаа хэрэгжилтийг олон нийтэд хүргэх дээрээ санаа зовох ёстой уг нь баймаар байх юм. Тэр нь уг нь бид гэртээ харьж болохгүй гэж байгаа юм. Гол нь сүүлийн үед ахуйн архидалт нэмэгдээд, тэрүүний араас хүүхдийн эрх зөрчигдөж байгаа, хүчирхийлэлд өртөж байгаа асуудлууд нэлээдгүй байгаа энэ танай тайлан дээр ч дурдагдсан байна лээ. Үүнийг уг нь сайжруулахын төлөө ингээд бид олон нийтэд мэдээлэл үүнийг чангатгая гэсэн, харамсалтай нь үүнийг ингээд бас л хүүхдийн эрхийг хамгаалах ёстой байгууллагууд нь энэ бүтэц нь ерөөсөө яахгүй байна. Дараачийн асуудал нь бид уг нь Хууль зүйн сайд Энхбаяр Гэр бүлийн тухай хуулийг өргөн барина гэсэн. Энэ хууль бас.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Асуултад хариулъя. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Ж.Хунан: Булгантуяа гишүүний асуултуудтай бүгдтэй нь санал нэг байна. Үндсэндээ энэ хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь холбогдох байгууллагуудаас нь асуух нь зөв байх. Та түрүүн хэллээ Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга өнгөрсөн оны 1 сард баталсан, 9 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн. Бидэнд байгаа мэдээллээр өнөөдрийн байдлаар ХЗДХЯ-нд 2 л журам бүртгүүлсэн байна. 14 журмаас 2-хон журам бүртгүүлсэн. 6 стандартаас 2-хон стандарт батлагдсан ийм мэдээлэл байгаад байгаа юм. Тэр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийг хамгаалах энэ журам маань өнөөдрийг хүртэл гараагүй байгаад байгаа юм. Үүнтэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрх зөрчигдөх энэ эрсдэл байсаар байгаад байгаа юм.

Энэ өнгөрсөн онд хүүхдэд оногдуулж, хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэж байгаа бэлгийн хүчирхийлэл үйлдэгчид ялыг чангатгасан. Дээрээс нь өршөөхгүй байх, магадланд орохгүй байх энэ нөхцөлийг бүрдүүлсэн. Тэгээд бидэнд 2024 онд ирсэн мэдээллээр нийтдээ шүүхээр ял шийтгүүлсэн болон суллагдсан байдлыг үзвэл хугацаанаас өмнө суллагдсан 5 тохиолдол байна. Өвчний учир ялаас чөлөөлөгдсөн 3 байна. Монгол Улсын Дээд шүүхээс цагаатгасан 2 байгаад байгаа юм. Тэгэхээр энэ шалтгааныг холбогдох эрх бүхий албан тушаалтнаас нь тодруулах нь зөв байх. Энэ бол нөгөө Монгол Улсын Хууль зүйн сайдын гаргасан энэ бодлоготой зөрчилдөж байгаа л асуудал шүү дээ.

Гэр бүлийн орчинд гэмт хэрэг, ялангуяа хүүхдийн хүчирхийлэл үйлдэгдэж байгаа энэ бол ил байгаа. Ер нь бүх талын судалгаагаар энэ маш тодорхой болчихсон. Түрүүн Батжаргал гишүүн ярьж байна. Ер нь хүн урлана гэдэг чинь өөрөө их нарийн ажил. Бид сургуулиас гадна сургуулийн бус арга хэмжээгээр дамжуулж, гэр бүлээр нь дамжуулж, өөрөөр хэлбэл гэр бүлтэй нь ажиллах энэ ажил маань үнэхээр сул байгаад байна. Өнөөдөр Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газар маань энэ хүчирхийлэлд байгаа хүүхдийг, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг, гэр бүлийг илрүүлэх үүрэгтэй. Илрүүлсний үндсэн дээр тухайн

гэр бүл, тухайн хүүхдийн нөхцөл байдалд таарсан арга хэмжээг төлөвлөж, авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Гэтэл энэ нь өнөөдөр хийгдэхгүй байгаад байна. Яагаад хийгдэхгүй байгаад байгаа юм бэ гээд шалтгааныг нь үзэхээр үнэхээр эргээд төсөвтэй холбогдоод байгаа юм. Төсөв хангалттай тавигддаггүй, өөрөөр хэлбэл бид өнөөдөр хүүхдээс төсвөө харамлаж байгаа асуудал. Боловсон хүчин, мэргэшсэн боловсон хүчин алга. Өнөөдөр мэргэшсэн гэр бүлийн асуудлаар мэргэшсэн сэтгэл зүйч ховор байгаад байна, хүүхдийн асуудлаар мэргэшсэн сэтгэл зүйч ховор байгаад байна.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Ажлын хэсгийн 11 дүгээр микрофон нэмж хариулъя.

С.Энхболд: Та бүхний өдрийн мэнд хүргэе. Энхболд гишүүн байна. Энэ бага насны хүүхдийн бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт дээр өнгөрсөн хууль батлагдсанаас хойш нэг ийм зөрөөтэй ойлголт яваад, өөрөөр хэлбэл хууль, Эрүүгийн хуулийг буцааж хэрэглэнэ, хэрэглэхгүй гээд. Үүнтэй холбоотойгоор хугацаанаас өмнө тэнсэн суллах асуудал дээр ийм зөрөөтэй ойлголт гарсантай холбоотойгоор энэ хүмүүс суллагдсан байхыг үгүйсгэхгүй. Ингээд Улсын дээд шүүхээс 2024 онд энэ журмыг бага насны хүүхдэд ор тас хэрэглэхгүй гэдэг ийм шийдвэр гаргаад, өнөөдөр энэ журмыг огт хэрэглэхгүй байгаа юм 1-д.

2 дугаарт нь одоо энэ хорих ангиудад байгаа хүмүүс дунд энэ бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой маш олон хүн байна. Тэгээд энэ бол удахгүй ингээд яваандаа хүссэн, хүсээгүй суллагдана. Тэгэхээр энэ дээр бид тэр тавих хяналтын эрх зүйн зохицуулалтаа маш оновчтой, шуурхай батлахгүй бол 5-аас 6 жилийн дараа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ц.Идэрбат: Өдрийн мэнд хүргэе. Хүний эрхийн асуудал яригдахад тэгээд л цагдан хорих, өмгөөлөл, мөрдөн, хорих анги гээд л яригддаг байсан бол энэ нийгмийн өөрчлөлттэй уялдуулаад энэ чинь шинэ, шинэ юмнууд их орж ирдэг байна л даа. Энэ цахим орчин дахь хүний эрхийн асуудал бүр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дүгнэлт дээр хүртэл гарч ирж байна л даа. Тэгээд өнгөрсөн долоо хоногт энэ цахим орчин дахь хүний эрхийн асуудлыг хөндөж ярьсан. Тэгээд сая яг л нөгөө Булгантуяа гишүүний ярьдаг шиг тэгээд цахим орчны энэ асуудлыг хөндөхөөр ингээд хамгийн тэнэг хүн болж л хувирсан л даа. Гэтэл энэ маань бид энэ чуулганы танхимд нэг үнэхээр ярихгүй, хэлэхгүй бол болохоо больсон байна гэдэг нь энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын асуудал дээр орж ирж байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр холбогдох хуулиуд дээрээ яаралтай өөрчлөлт юмнуудаа хийхгүй бол ер нь болохоо байлаа гэсэн ийм дүгнэлтийг Хүний эрхийн Комисс гаргасан байна. Тэгэхээр энэ дээр ер нь хуулийн ямар өөрчлөлтүүдийг та бүхэн хийх шаардлагатай гэж үзэж байгаа юм бэ гэсэн эхний асуулт.

2 дугаарт энэ хүүхдийн бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой асуудал байна. Хүүхэд хамгааллын хууль дээр яг үнэндээ аргаа барахдаа л тэр заалтыг оруулсан шүү дээ. Ойр дотных нь хүмүүс гэрт нь ирж архи уудаг согтуурдаг, тэгээд л ийм үйлдлүүд хийдэг. Тийм учраас тэгээд айлд ер нь согтуу архи барьж орж болохгүй

гэсэн ийм л зүйлийг оруулсан. Бас л сошиалаар л нэг хэдэн тэнэг юмнууд нэг хачин хууль баталлаа гээд л нэг баахан юм болсон. Гэхдээ өнөөдөр бид энэ Их Хурлын танхим дээр ялангуяа энэ нийгэмд болохгүй байгаа юмнуудыг ил гаргаж ярьж, засахын төлөө байхаас биш, тэгээд хэлчихвэл тэнд алуулах болов уу, сошиалд нь алуулах болов уу гээд ингээд дандаа сайн сайхан юм яриад байж болохгүй байгаа юм л даа. Тийм учраас энэ ХЭҮК дээр сая энэ хүүхдийн бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой асуудал дээр одоо ингээд нэг хууль нь хэрэгжээд, холбогдох албан тушаалтнууд нь томилогдоод ингээд явж байгаа. Тэгээд энэ хуулийн хэрэгжилт яг л тэр баг, хороон дээр хэрхэн яаж хэрэгжүүлэх вэ, хэрэгжилт нь ямар байгаа вэ гэдэг дээр тодорхой хугацааны дараа үнэлэлт, дүгнэлт өгвөл арай өөр үр дүн би гарах болов уу гэж бодож байгаа юм.

Нөгөө талдаа энэ болгоныг бид нэг жоохон тийм сурталчлах, ялангуяа хүүхдүүдэд, бага насны хүүхдүүдэд өөрийнхөө эрхийг хамгаалах тал дээр хэрвээ танай гэрт хүсээгүй байхад чинь нэг хүн ирээд ингээд архи дарс уугаад байвал шууд мэдээлдэг энэ талынх нь юмнуудыг хийж хүүхэд өөрөө өөрийгөө хамгаалах юм руугаа орохгүй бол болохгүй юм байна лээ яг амьдрал дээр бол. Тийм учраас би Хүний эрхийн Үндэсний Комиссын энэ дүгнэлтүүдийг тодорхой хэмжээнд өнөөдөр Их Хурал дээр нээлттэй ярьж байгаа шиг нийгэмд хүний эрхийн нөхцөл байдал ийм байгаа талаар, дүгнэлт юмаа танилцуулах тийм бололцоо байдаг юм болов уу гэсэн ийм 2 дахь асуулт.

3 дахь нь яг өнөөдөр манай зүүн бүсийн төрийн албан хаагчдын зөвлөгөөн манай Хэнтий аймагт болж байна л даа. Тэгээд биднийг урьсан. Гэхдээ бид чуулганы хуралдаантай байна 1 дүгээрт. 2 дугаарт тэнд очиж амжилт хүсэж байхаасаа илүүтэйгээр энэ төрийн албан хаагчдын эрх ер нь яг хэн хамгаалж байх ёстой юм болоо. Энэ чинь аягүй туйлын төвөгтэй байдалд орчхоод байгаа шүү дээ. Төрийн албаны зөвлөл хууль хэрэгжүүлэх л юм яриад байдаг. Одоо энэ төрийн албанд орохгүй ажиллахгүй. Ялангуяа орон нутагт ингээд явж байхад сургуульд багш олдохгүй байгаагийн нэг томоохон хүчин зүйл нь бол энэ төрийн албан хаагчид багш сурган хүмүүжүүлэгчдийн талаар өмгөөлж дуугардаггүй гэдэг ийм зүйлийг ярьж байгаа шүү. Тэгэхээр ер нь энэ дээр Хүний эрхийн комиссынхон энэ төрийн албан хаагчдын эрхийн асуудал дээр ер нь яг ямархуу байдалтай байдаг юм бол? Энэ үйлдвэрчний эвлэлүүдийг хараад байхаар эрүүл мэнд, боловсрол, тэгээд аль болох л ийм олон хүнтэй салбарууд дээр үйлдвэрчний эвлэл нь ажиллаад байдаг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүнд 1 минут нэмж өгье.

Ц.Идэрбат: Тэгэхээр энэ төрийн албан хаагчдын эрхийн асуудал ч гэсэн би ярих л ёстой ийм сэдэв. Мэдээж хууль мөрд, шахах гэх нь аргагүй. Татвар төлөгчдийн мөнгөөр цалинжиж байгаа ёс зүйн өндөр хариуцлага ярих нь зүйн хэрэг. Гэхдээ нөгөө талдаа энэ хүмүүсийн эрх ашгийг нэг хамгаалдаг дуугардаг байхгүй бол энэ төр улам л хүчгүй болох ийм юм руугаа ороод байдаг юм. Тэгэхээр энэ ХЭҮК-оос төрийн албан хаагчдын эрхтэй холбоотой асуудлууд байдаг уу гэсэн 3 дахь асуулт асууж? Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Г.Нарантуяа: Идэрбат гишүүний цахим технологитой холбоотой асуултад хариулъя. Тэгэхээр мэдээж энд цахим технологи гэхээр олон нийтийн сүлжээнээс гадна ер нь өгөгдөл мэдээллийг цуглуулж боловсруулдаг бүх төрлийн цахим технологи, байршил тогтоогч, ухаалаг гар утас гэдэг юм уу, камерын хяналт гээд өргөн хүрээтэй мэдээллийг боловсруулдаг технологиудыг хүний эрхийн эрсдэлийг үнэлсэн. Энэ дотроо яалт ч үгүй Монгол Улс бодлого тодорхойлох, чиглэлээ тодорхойлох шаардлагатай асуудал бол олон нийтийн сүлжээ сошиал, медиа платформууд байгаа. Тэгэхээр жендерт суурилсан хүчирхийлэл сошиал медиа платформууд дээр үндэслэж гэмт хэргийн шинжтэй, үзэн ядалтын шинжтэй, эмэгтэйчүүдийг үзэн ядуулах, жигшээх, гутаан доромжлох, бэлгийн сэдэлтэй ийм контентууд их явж байгаа. Тэгэхээр олон нийтийн сүлжээг зохицуулахад нэг талаасаа үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, нөгөө талаасаа худал мэдээлэл, гэмт хэрэг зөрчлийн шинжтэй хоруу контентыг хязгаарлах энэ зохистой тэнцвэрийг хангасан бодлогыг Монгол Улс тодорхойлох цаг нь болжээ гэж ХЭҮК дүгнэсэн. Энэ бодлогыг тодорхойлох зөвлөмжийг өгсөн байгаа.

Дэлхийн улс орнуудын практикийг бид энэ олон нийтийн сүлжээний зохицуулалт Монгол Улсад ямар байх ёстой вэ гэсэн бие даасан үнэлгээний ажил яг үргэлжилж байгаа. Одоо ямар ч байсан Монгол Улсын Засгийн газар, Улсын Их Хурлаас бодлогоо тодорхойлох шаардлагатай байна гээд ХЭҮК өөрийнхөө ингэж зохицуулбал боломжтой юм гэдэг хувилбарыг тун удахгүй 12 сарын 10-нд Хүний эрхийн форумын өдрөөр танилцуулах юм. Тэгэхээр дэлхийн улс орнууд олон нийтийн сүлжээг өөрийн зохицуулалтад тулгуурлаад эсвэл хамтарсан байдлаар өөрийн зохицуулалтыг ашиглаж, мөн уламжлалт гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх механизм, одоо байгаа хууль, эрх зүйн механизмтайгаа хоршиж эсвэл бие даасан хууль гаргах замаар зохицуулж байгаа. Тэгэхээр энэ дээр чухам сошиал медиа платформууд Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаггүй учраас бид зохицуулж чадах орон зай бий, чадахгүй орон зай бий. Олон улсын хамтын ажиллагаанд түшиглэж гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх, мөрдөн шалгах энэ чадавхаа бэхжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх ийм гарцаагүй шаардлага байгаад байгаа. Гэмт хэргийг мөрдөн шалгах тогтолцоо манай Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Эрүүгийн хуулийн маш тодорхой хэдэн заалтууд бол цахим технологийн нөхцөл байдлыг харж нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна гэдэг энэ тодорхой саналуудыг тавьсан байгаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 8 дугаар микрофон Сүнжид дарга нэмж хариулъя.

Д.Сүнжид: Идэрбат гишүүний 2 асуултад нь нэмж тодруулъя. Өмнө нь Алтаншагай гишүүний асуултад гарсан сургалт сурталчилгааны талаар асуулт гээд. Тэгэхээр Хүний эрхийн үндэсний байгууллага бол хүний эрхийн албан бус боловсролыг манлайлах энэ чиглэлээр үүрэг хүлээдэг. Илүүтэй бид төрийн албан хаагчдыг сургагч багшаар бэлтгэхэд 1 дүгээрт төлөвлөгөө стратеги чиглэж байна. 2 дахь нь сурагчид, сурагчдыг дагаад багш нар, нийгмийн ажилтнууд гээд энэ хэсэг рүү 2, 3 бүлэг болгож бид сургалтаа төлөвлөдөг.

2 дахь асуултад нь хариулъя. Төрийн албан хаагчдын эрх зүйн байдалтай холбоотой. Төрийн албан хаагчдын өмнөх 22 дахь илтгэлээр Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 22 дахь илтгэлд бид энэ талаар авч үзсэн. Авч үзэхээр хууль тогтоомжийн хэрэгжилт ямар

байна, уялдаа холбоо ямар байна, цалин хөлс, нийгмийн баталгаа, түүнээс гадна хүний нөөц дутагдаж байгаа салбарт хэрхэн яаж нөхөх юм бэ гэдэг дээр 2 байгууллага ЗГ-ын түвшинд яам, яамд, ЗГ-ын түвшинд 1 дүгээрт энэ хүний нөөц.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сүнжид дарга гүйцээж хариулъя.

Д.Сүнжид: Энэ хүний нөөцийн дутагдлаа хэрхэн яаж даван туулах талаар төлөвлөгөө боловсруулах, бодлогоо тодорхойлох нэг хэрэг байна. 2 дугаарт Төрийн албаны зөвлөл дээр энэ бодлогоо тодорхойлох бас нэг хэрэг байна. Бид ер нь бүхэл нь энэ төрийн албан хаагчдын нөхцөл байдал, цалин хөлсний баталгаа, тоо, чиг үүргээ гүйцэтгэж чадаж байгаа эсэх, энэ нь улмаар төр өөрөө чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх боломж нөөцийг хангаж байгаа эсэх дээр дүгнэлт хийх шаардлагатай ийм болсон гэж үзэж байгаа. Энэ талаараа 22 дахь илтгэлдээ тусгасан.

Д.Амарбаясгалан: Идэрбат гишүүн тодруулж асууна.

Ц.Идэрбат: Их Хурал дээр Хүний эрхийн Үндэсний Комиссын энэ дүгнэлтийг ингээд танилцаж байгаа нь өөрөө олон эерэг үр дүн авчрах байх. Хүний эрхийн хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хадгалж явах ёстой, нөгөө талдаа хөндөгдөх ёстой асуудлуудаа хамгаалах ёстой ийм л зүйл байгаа юм билээ. Тэгээд би нэг зүйлийг их сонирхоод байна л даа. Яагаад ингээд энэ хүний эрхийн асуудал цахим орчин дахь юмыг ярихаар жендерт суурилсан гэдэг, тэгээд ер нь ингээд эмэгтэйчүүд л голдуу дээрэлхүүлээд байна гэсэн ийм судалгаа бүр яг жендерт зориулж гэж ингэж хийсэн юм уу? Би бол энэ цөөхөн Монголчуудын эрх л гэж ингэж, Монгол хүний эрх ашиг л гэж яримаар санагдаад байдаг юм. Энэ сургуулиуд дээр энэ сошиал орчин дээр ч гэсэн зөндөө л явагдаад харагдаад байгаа шүү дээ. Хөвгүүд нь охидоо зодохоо байсан, охид нь хөвгүүдээ зоддог болчихжээ. Хөвгүүдээ эмэгтэй хүнд битгий гар хүр, битгий ингэ гэдэг, охид нь хөвгүүдээ цохиод байна гээд байгаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 8 дугаар микрофон Сүнжид дарга.

Д.Сүнжид: Нэгдсэн Үндэстний Байгууллагын охид, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах ажлын хэсэг гээд энэ сүүлийн 3 жил үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ ажлын хэсгийн дүгнэлтэд технологи ашиглан үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийлэл гээд ийм нэр, шинэ нэр томъёог ашиглаад. Яагаад вэ гэхээр дэлхийн улсуудын хэмжээнд хийсэн судалгаагаар өртөгч болоод хохирогч болоод байгаа нь илүү эмэгтэйчүүд юм байна, охид юм байна. Тэгэхдээ таны хэлж байгаатай адилхан залуучууд насны хувьд илүү залуучууд, өсвөр насныхаа хүүхдүүд өртөөд байна, хохирогч болоод байна гэдгээр энэ нэр томъёо олон улсын түвшинд хэрэглэгдээд яваад байгаа учраас ХЭҮК тэр хэвээр нь авсан. Тэгэхдээ мэдээж хүний эрх гэдэг утгаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан энэ бүх эрхүүдийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих, зөрчигдсөн тохиолдолд сэргээх ёстой гэдэг байр суурийг ХЭҮК байнга илэрхийлдэг. Бүлгийн эрхүүдийн хувьд нь ямар асуудал байна вэ гэдгийг тусад нь нарийвчлан авч үзэж дүгнэдэг.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Би энэ ХЭҮК тухай тухайн жилийнхээ сэдвээ хэрхэн яаж сонгодог юм бэ гэдгийг нь асууя. Та бүхэн өөрсдөө дотроо ярилцаж байгаад сонгочихдог юм уу эсвэл нийгмийн захиалга гэдэг юм уу, судалгаа юмны үндсэн дээр гэдэг юм уу ингэж сонгодог юм уу? Энэ жилийн сонгосон 6 сэдэв үнэхээр л энэ цаг үед яахын аргагүй хүний эрхийн зөрчил, анхаарал хандуулах ёстой асуудлууд мөн үү гэвэл мөн байна. Нөгөө талаар юу асуух гэж байна вэ гэхээр Улсын Их Хурал Улсын Их Хурлын өөрийнх нь баталсан хүний эрхийн зөрчилтэй хуулиуд, баталсан хуулийн хүрээнд албан үүргээ гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид буруутах, ингэснээрээ ял зэм авах асуудлууд байсаар байна. Тийм учраас ХЭҮК зүгээр дараагийн 25 дахь илтгэлд нь захиалга өгч болох уу, үгүй юу сэдэвт нь. Энэ Улсын Их Хурал, ЗГ-аас баталсан хууль, дүрэм, журмуудын хүрээнд хүний эрхийн зөрчилтэй хууль тогтоомжууд ямар байна вэ гэдгийг ХЭҮК-оос нэг гаргаж өгч болох уу, үгүй юу?

Яагаад гэхээр Улсын Их Хурлын баталсан хуулиудаас албан, баталсан хуулийн хүрээнд ажиллаж албан үүргээ гүйцэтгэж яваад төрийн албан хаагчид буруутгах асуудал байна. Тодорхой кейс хэлье. 2008 оны 7 сарын 1 тухайн үеийн цагдаа, хууль хүчний байгууллагын удирдлагууд Амарболд, Ганболд гээд дарга нар албан үүргээ гүйцэтгэснийхээ төлөө ялтан болоод ял аваад, шоронд орж байсан асуудлууд бий. Төрийн захиргааны албан хаагчид буруутгах асуудал үүсэж байна. Саяхан сарын өмнө болсон ногоон автобусны хэргээр ажилд ороод удаагүй байсан цоо шинэ залуу төрийн албан хаагчид буруутан болоод яах гэж энэ албанд оров доо гээд харамсаж байна гээд шүүхийн өмнө яриад зогсож байсан. Ахиад нэг кейс хамгийн сүүлийн жишээ. Төрийн үйлчилгээний албан хаагчид, Батчулуун эмч хүний амь насны төлөө ажил албан үүргээ гүйцэтгэснийхээ төлөө өнөөдөр ялтан болоод ингээд зогсож байна. Энэ бол Улсын Их Хурлын өөрийн баталсан хуулийн хүрээнд төрийн албан хаагчид албан үүргээ гүйцэтгэснийхээ төлөө ял зэмтэй болоод явж байгаагийн нэг тодорхой жишээнүүдийг би хэлэх гэж байгаа юм.

Тэгэхээр энэ асуудлууд дээр Улсын Их Хурал онцгой анхаарал хандуулж, энэ парламент дээр хэд хэдэн эрүүл мэндийн салбарт эмч хийж байсан улсууд гишүүд сонгогдсон. Жишээлбэл энэ Батчулуун эмчийн асуудал дээр онцгой анхаарал хандуулж, энэ хууль юмандаа өөрчлөлт оруулах болдоггүй юм уу Их Хурлын даргаа, үүрэг чиглэл өгч болохгүй юу? Энэ өөрөө нэг эмчийн асуудал гэхээсээ илүүтэйгээр эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа энэ олон эмч нарын сэтгэл зүйд асар том цохилт болж байгаа юм байна лээ. Албан үүргээ гүйцэтгэснийхээ төлөө хэн ч, хэн маань ч буруутан болох эрсдэлтэй юм байна гээд ямар ч ажлын урам зориггүй, ямар ч сэдэл санаагүй ийм болж хувирч байгаа юм байна лээ. Тийм учраас ХЭҮК цаашдаа энэ Улсын Их Хуралд ирэх жилийн тайлан илтгэлдээ өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа энэ 700, 800 гаруй хуулиудад хүний эрхийн зөрчлийн асуудал юу байна вэ? Энэнд нэг дүгнэлт өгч, энийг цаашдаа нэг засаж залруулах асуудлыг. Сүүлийн үед Улсын Их Хурал парламент хүний эрхийн асуудлыг маш их ноцтой анхаарал хандуулж ярьдаг болсон. Энэ үүднээсээ энэнд үнэлгээ дүгнэлт өгөх цаг болсон юм биш үү? Энэ дээр Хүний эрхийн Комисс ажиллаж өгөөч 1-д.

2-т цаашдаа Улсын Их Хуралд шинээр орж ирж байгаа хууль тогтоомжууд дээр Засгийн газрын яамнуудаас санал авахаас илүүтэйгээр ХЭҮК-оос тухайн орж

ирж байгаа хууль дээр хүний эрхийн зөрчлийн асуудал байгаа эсэх дээр санал авдаг байх.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сандаг-Очир гишүүнд нэмж минут өгье.

Ц.Сандаг-Очир: Энэ орж ирж байгаа хуулиуд дээр ХЭҮК-оос баталсан хуулийн араас нь зөрчил байна гэж ярих биш, урьдчилан орж ирж байгаа хуулиуд дээр ХЭҮК-оос хүний эрхийн зөрчил байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж, саналыг нь авдаг байх энэ асуудал руу анхаарал хандуулбал үнэхээр энэ парламент хүний эрх дээр онцгой анхаарал хандуулдаг болсон юм байна гэдэг нэг ахиц дэвшил гарах болов уу гэж би хувьдаа бодож байгаа. Энэ дээр цаашдаа парламент анхаарч өгвөл их сайн байна. Энэ дээр Их Хурлын дарга саналаа хэлээч, манай Хүний эрхийн Үндэсний Комиссынхон саналаа хэлээч гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Сандаг-Очир гишүүн маш чухал сэдвийг хөндөж байгаа юм. Монгол Улсад батлагдсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудад хүний эрхийн зөрчил үүсгэх заалтууд ер нь хэд хэчнээн байна вэ гэдэг талаар 2021 оноос хойш хийсэн судалгаа дээр тодорхой гараад ирчихсэн. Өдөр тутамд нийгмийн харилцааг зохицуулж байгаа өргөн цар хүрээтэй 350 орчим хуулийн 800 гаруй заалт нь хүний эрхийн зөрчил үүсгэж байна гэдэг нэг дэх дүгнэлт гарч байгаа. 2 дахь том дүгнэлт нь шинэ тутамд бий болж байгаа нийгмийн харилцааг хуулиуд нь зохицуулж чадахгүй байгаад байгаа байдал нь ахиад хүний эрхийн зөрчил үүсгэж байна, хүний эрхийг хязгаарлаж байна гэдэг 2 дахь дүгнэлт гарч ирсэн.

Тэгээд үүнтэй холбогдуулаад өнгөрсөн жилээс эхлээд Улсын Их Хурал дээр Улсын Их Хурлын 3 төгөлдөршлийн бодлого буюу Хүн төвтэй хууль, эрх зүйн орчныг бий болгох бодлого бол Улсын Их Хурлын түвшинд хэлэлцэгдэж батлагдаад, ажил хэрэг болоод явж байна. Үүний хүрээнд Улсын Их Хурлын даргын захирамжаар 60 гаруй ажлын хэсэг байгуулагдаад, Улсын Их Хурлын гишүүд өөр өөрсдийн мэргэжил чиглэлийн дагуу хуулиудыг ажлын хэсэг ахлаад ажиллаад эхэлчихсэн. Хамгийн түрүүнд Хууль зүйн байнгын хорооны дарга Дамдины Цогтбаатар нарын өргөн мэдүүлсэн байгаа одоо Улсын Их Хурал дээр хэлэлцэгдэж байгаа хууль байна. Энэ хууль бол Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хууль. Цаашид Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж батлагддаг хуулиуд нь өөрөө үзэл баримтлалын хувьд хүний эрхийг хязгаарласан, хүний эрхийг зөрчсөн зүйл, заалт, үзэл баримтлалгүй байхыг анхаарч ажиллах зорилготойгоор энэ Хууль тогтоомжийн хууль хэлэлцэгдэж байж байгаа юм. Энэ өргөн барьсан хуулийн төсөл дотор Хүний эрхийн Комиссын үүрэг оролцоог анх удаагаа маш тодорхой зааж орж ирж байна. Яг таны саяын хэлсэн хуулийн төслийг өргөн мэдүүлэхдээ процесс дундаа Хүний эрхийн Комиссоос уг төсөл нь хүний эрхийн зөрчилтэй байна уу, үгүй юу гэдэг дээр дүгнэлт гаргах эрхийг Монгол Улс анх удаа нээх гэж байгаа юм. Тэгэхээр цаашдаа батлагдах хуулиуд хүний эрхийн зөрчил үүсгэх тэр алхмыг бий болгохгүй гэдэг энэ чиглэл дээр явж байна.

2 дахь маш чухал зүйл өнөөдөр мөрдөгдөж байгаа хуулиудын үзэл баримтлал нь хуучин нийгмийн арга барилтай, үзэл баримтлалтай байна гэдэг дүгнэлтүүдийг эрдэмтэд судлаачид гаргаад байгаа юм. Нэг ёсондоо хууль хүнийхээ эрхийг хангах, хамгаалах чиглэл дээр үндсэн зорилго нь байх ёстой юм. Тэгэхгүй бол өнөөдөр байгаа хуулиуд нь дийлэнх нь төрийн ажлыг явуулах, албан байгууллагуудын процессын үйл ажиллагааг зохицуулахад зориулагдаад байна

гэж байгаа юм. Тэгэхээр тэдгээр хуулиуд үзэл баримтлалын хүрээнд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэл дээр очиж өөрчлөлт орох шаардлага байна гэдэг асуудал. Тэгэхээр манай энэ парламент ирэх 4 жилийн хугацаанд яг энэ үзэл баримтлал дээрээ төвлөрч, Улсын Их Хурлын гишүүд маань нам харгалзахгүйгээр хүний эрхийг хангах чиглэл дээр анхаарлаа төвлөрүүлж ажиллаж чадвал энэ хуулиудыг бид бүрэн өөрчлөх суурийг бат бөхөөр нь тавьж чадах юм л гэсэн ийм байдлаар ажиллаж байгаа гэдгийг Сандаг-Очир гишүүндээ хэлье. Нэмээд Хүний эрхийн Комиссын дарга Сүнжид доктор хариулт өгнө.

Д.Сүнжид: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя 3 зүйл. 1 дүгээрт ямар байдлаар сэдвээ сонгодог вэ. Хүний эрхийн Үндэсний Комиссын стратегийг 2020 онд баталсан. Энэ стратегид тулгуурлаж сонгодог. Тэгээд 2-т нь энэ стратегид ямар эрхүүдийг авч үзсэн бэ гэвэл өнгөрсөн хугацаанд бид төдийлөн авч үзээгүй орхигдсон бүлгүүд байгаа. Тэд нарын эрхийг бид судалж дүгнээ гэдэг нэг. Өнөө цаг үед чухал ач холбогдолтой асуудлууд байна. Тэд нарыг дүгнээ. 3 дахь нь шинээр шинэ тутам үүсэж байгаа эрхийн асуудлыг бид авъя гэдэг ийм 3 чиглэл стратегийн хүрээнд бид сэдвийг сонгож авдаг.

2 дахь асуултын хүрээнд, эрх, энэ 25 оны илтгэлд бид ялангуяа энэ шийтгэл оногдуулж байгаа байдлын үр дүнтэй холбоотойгоор хууль хоорондын зөрчлийг давхардал, хийдэл, зөрчлийг судалж болох уу гэвэл болно. Тэгээд энэ маш чухал санаа бол Амарбаясгалан дарга хэлээд байна. Бид заримдаа асуудлыг зохицуулахын төлөө яваад үндсэн зорилгоо, яг ямар үр дүнд хүрэх гэж байгаагаасаа хазайгаад байгаа ийм олон асуудлууд гарч ирдэг. Нэн яаралтай горимоор баталсан хуулиуд маш их зөрчилддөг. 2 дугаарт бид хууль тогтоохдоо олон зорилтот бүлгийн эрх ашгийг тэнцвэржүүлэх, нэгэнд нь сөрөг үр дагавар үүсэж байгаа бол нөгөөд нь эерэг үр дагавар үүсгэж болзошгүй гэдгийг нь гээдэг. Дараагийн асуудал нь төсөв, нөөц, механизм хүрэлцээтэй юм уу, үгүй юү гэдгийг бид хангалттай бодоогүйгээс дараа нь хэрэгжилт дээр олон асуудал тулгардаг ийм жишиг заримдаа тогтчихоод байгаа харагддаг.

Тиймээс бид үүнийг даван туулахын тулд эцсийн эцэст үр дүнтэйгээр тэр салбарын харилцааг зохицуулж байгаа юу, хүний эрхийг бид яг бодитойгоор хангах ийм боломжийг нь бүрдүүлж байгаа юу, үр дагавар нь бодсончлон гарах уу гэдгийг урьдчилан таамагласны үндсэн дээр хууль тогтоомжийг судалгаа, дүн шинжилгээ, үр дагаврын үнэлгээнд тулгуурлан цаашдаа боловсруулж байх нь зүйтэй гэдэг таны саналыг бүрэн дэмжиж байгаагаа илэрхийлье.

Д.Амарбаясгалан: Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууж, үг хэлье.

О.Саранчулуун: Сайн байна уу. Надад нэг хэд хэдэн асуулт байна. Хүний эрх ба цахим технологи гэдэг бүлэг байна. Эндээс харвал төрийн үйлчилгээ өөрөө цахим салбарын маш том тоглогч, төрийн үйл ажиллагааг авч байгаа төрийн үйлчилгээг хүртэх гэж байгаа ихэнх иргэд нь бас л нөгөө ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нэлээн их жинг эзэлнэ. Тэгэхээр энэ төрийн цахим үйлчилгээ нэлээн олон газар асуудалтай байгаа, хүртээмжгүй байгаа. Энэ талаар ямар зохицуулалт шийдэл байгаа вэ? Энэ дээр, энэ дүгнэлт дээр харахлаар цахим дээрэлхэлтийн асуудал руу илүү анхаараад, яг төрийн үйлчилгээ өөрөө цахимаар хүргэхтэй холбоотой зөвлөмж, дүгнэлт их бага харагдаж байна л даа. Тэгэхээр энэ дээр ямар зохицуулалтыг оруулах вэ гэж санал асуумаар байна.

Дараа нь тайлангийн 6 дугаар хуудсан дээр Хүний эрхийн Үндэсний Комиссын стратеги болон гомдолд үндэслэн энэ сэдвийг сонгодог юм байна гэж тайлбарласан байна. Би стратегийг хайгаад олсонгүй л дээ веб сайт дээр нь ямар стратеги байдаг юм бол гээд. Яагаад хайх гэж байгаа вэ гэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал энэ стратеги дотор хэр их туссан байгааг харахыг хүссэн юм. Тэгвэл саналаа хэлэх боломжтой байгаад байдаг. Гэтэл ингээд олохгүй байгаа учраас надад тэн дээр хариу өгнө үү?

Дараа нь гомдолд үндэслэн гэж байгаа юм. Гомдлоо илэрхийлж чадахгүй байгаа хүмүүсийн гомдол тэгээд яах уу, энэ чинь өөрөө хүртээмжтэй биш байна шүү дээ. Тэгэхээр гомдолд үндэслэн гэвэл цөөхөн хүн гомдлоо өгчихсөн байхад энэ бол цөөхөн хүн өгсөн юм чинь энэ асуудлыг анхаарахгүй гээд орхино гэсэн үг үү? Гомдол өгөх механизмынхаа талаар хэзээ энийгээ сайжруулах юм, хэзээ хүртээмжтэй болох талаар хариулт авмаар байна.

Дараагийнх нь орон гэргүй байгаа, бие даан амьдрах чадваргүй, хүний эрхэнд байгаа хөгжлийн бэрхшээлтэй олон зуун хүмүүс байна. Хүний эрхийн комисс гэдэг байгууллагын тухай бараг мэдэх ч үгүй. Гэхдээ тэр хүмүүс Монгол Улсын иргэн. Тэгэхээр тэр хүмүүсийн эрхийг хэн хариуцах вэ, яах ёстой вэ гэдэг дээр нэг ийм мэдээлэл авмаар байна.

Дараа нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс болон НҮБ-ын хүний эрхийн зөвлөмжүүдэд удаа дараа тусгагдаж ирсэн тодорхой асуудлууд байдаг. Түүн дээр нэг зүйлийг нэлээн их ярьдаг. Ялгаварлан гадуурхлын эсрэг энэ хууль тогтоомжийн хэрэгцээгээ байна гэж ингээд дүгнэсэн ийм өгүүлбэрүүд яваад байдаг. Та бүхэн бас мэдэж байгаа байх. Тэгэхээр ялгаварлан гадуурхалт хүнийг нас хүйс, гадаад төрх, хөгжлийн бэрхшээл зэргээр суурилад ялгаварлан гадуурхсан үндэстэй цахим дээрэлхэлт чинь яваад байна. Тэгэхээр цаашдаа энэ асуудал дээр бие даасан хууль тогтоомж ер нь хэрэгтэй юү? Энэ дээр би Хүний эрхийн Комиссын байр суурийг сонсохыг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Г.Нарантуяа: Цахим хуваагдалтай холбоотой асуултад хариулт өгье Саранчулуун гишүүний. Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлд төрийн цахимжилтын сайн жишээгээр орсон ийм санаачилга бол ИМонголиа систем. Өнөөдөр ИМонголиа системд хот суурин газрын иргэдийн 57,3 хувь, хөдөө орон нутгийн иргэдийн 55 хувь нь холбогдсон байгаа, үйлчилгээг авч байгаа. Тэгэхээр үлдсэн 40 хувь нь цахим хуваагдалд энэ үйлчилгээг даруй авах боломжгүй цахим хуваагдалд өртсөн иргэд дийлэнх нь байх магадлалтай. Тэгэхээр энэ хүмүүс төрийн үйлчилгээг авах энэ бодлого 1 дүгээрт нь арга хэмжээг бий болгох шаардлагатай гэдэг зүйлийг төрийн цахимжилтын суурь нөхцөлүүдийг үнэлсэн хэсэг дээр бид онцгойлон анхааруулсан байгаа.

Тэгэхээр энэ илтгэлийн 212 дугаар хуудсанд цахим хуваагдал тэгш бус байдал гэсэн асуудлаар ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, орлого багатай иргэд, хөдөөгийн хүмүүсийн асуудлыг, энэ дотроо ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн цахим технологийн хүртээмжийн асуудлыг авч үзсэн. Монгол Улсад цахим хуваагдал бодитойгоор оршин байна гээд ХЭҮК-оос гаргаж

байгаа санал бол, ХЭҮК-оос гаргаж байгаа санал би уншиж сонсоё. Тэгэхээр 7 дугаар санал. 3 дугаар бүлгийн 7 дугаар санал. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, орлого багатай болон хөдөөгийн өрх, Монгол хэлээр харилцах боломжгүй хүмүүсийн цахим технологийн хүртээмжийг дэмжих, тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн практик ур чадвар олгох сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүнийг боловсруулах, үр дүнтэй сургах, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шинжлэх ухааны дэвшлийн үр шимийг хүртэх эрхийг хангах асуудлыг тусгасан цахим хуваагдлыг сөрөх бодлогыг баталж, хэрэгжүүлэх гэсэн энэ саналыг Улсын Их Хуралд тавьж байгаа.

Д.Амарбаясгалан: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууж, үг, уучлаарай ажлын хэсгийн 8 дугаар микрофон Сүнжид дарга үг хэлье, хариулт өгье.

Д.Сүнжид: Саранчулуун гишүүний 3 асуултад нь хариулъя. Хүний эрхийн Үндэсний Комиссын стратеги веб хуудсан дээр ил байгаа. Ер нь нууц биш мэдээлэл. танд тусад нь хүргүүлье. Гомдол дээр тулгуурлаж гэдэг нь ер нь зөвхөн манайд ирсэн гомдол, түүнээс гадна бусад байгууллагууд иргэдээс хандаж байгаа асуудал ямар асуудлаар хамгийн их гомдол гарч байна вэ гэдэгт нь дүн шинжилгээ хийж, түүний үндсэн дээр бид боловсруулдаг юм гэдэг санаа. Түүнээс зөвхөн манайд ирсэн 1300 гомдлын хүрээнд л бид энэ асуудлыг авч үздэг биш.

2 дахь асуудал. Бид хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлыг 23 удаагийн илтгэлийн 10-д нь тусгайлан илтгэж байсан байна. Энэ 10-аас гадна бүлэг бүр дээр сурч боловсрох эрх, хөдөлмөрлөх эрх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрх гээд тухайлан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх нь энэ тухайд яаж хангаж байгаа вэ гэдгийг заавал энэ оруулж илтгэлдээ оруулдаг. Ер нь Хүний эрхийн Үндэсний Комиссын өөрийн стратегид нь байгаа зорилго 13 бүлэг байгаа юм. Энэ 13 бүлэг өөрсдийнхөө нэрийн өмнөөс гомдлоо гаргаад.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Энэ 1 дүгээр бүлэгтэй холбоотой сонгох, сонгогдох эрхтэй холбоотой энэ хэсэг дээрээс асуулт байна. Тэгээд Сүнжид даргын ярианы эхэнд Үндсэн хуулийн 3.1-ийн заалтыг дурдаж эхэлсэн. Тэгээд засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна, тэгээд сонгосон төлөөллийн байгууллагаараа дамжуулан энэ эрхээ эдэлнэ гэсэн. Тэгэхээр яах вэ ер нь Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг ингээд буцаагаад хараад байхаар яг энэ өөрчлөлтүүдийн үр дүнгээр ч юм уу иргэдийн ард түмний засаглах эрх улам энэ улс төрийн намуудад алдагдаад байгаа иймэрхүү дүр зургууд харагдаад байгаа юм. Тэгэхээр энэ чиглэлээр улс төрийн намуудыг илүү хариуцлагатай болгох ч юм уу яг энэ ард түмний энэ эрхийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагууд байгаад байгаа юм. Тэгээд энэ дээр энэ мөрийн хөтөлбөртэй холбоотой заалтыг асуулт байна? Өөрөөр хэлбэл өнгөрсөн хугацааны улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрүүдийг хараад үзэхээр сонгуульд орохдоо нэг юм ярьдаг, тэгээд яг эрх авангуутаа тэрийгээ хэрэгжүүлэхгүй, тэрийг нь хянадаг ямар ч үүрэг байхгүй.

Сонгуульд орохын өмнө жишээлбэл аудитын байгууллагаар хянуулдаг. Тэгээд тэрнээсээ болоод зарим улс төрийн намууд хүртэл сонгуульд оролцохгүй байх ийм нөхцөл байдал бий болдог. Тэгэхээр амлачихсан зүйлээ хэрэгжүүлэхгүй

байх, жишээлбэл бараг энэ төрийн эрх мэдлийг хууль бусаар авч байгаа юм шиг, залилан маягтай, жишээлбэл ийм, ийм юм хийнэ гэж жишээлбэл нийгмийн бүлгүүд дээр намын ажилтнууд нь хүртэл, нэр дэвшигчид нь хүртэл ингэж ярьж явж байгаа мөртөө яг эрх мэдэл аваад ирэхээрээ энэ ярьж байсан зүйлээсээ ухардаг. Тэгээд нэр дэвшигчдийн хувьд ч гэсэн, тэр намын сонгуульд ажиллаж байсан хүмүүсийн хувьд ч гэсэн их эвгүй байдалд ордог. Тэгээд энэ ингээд жишиг болчихоод байна л даа. Өнгөрсөн сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдийг харахаар. Эсвэл ингээд хийж чадахгүй юмнуудаа амладаг, тэгээд дараа нь ийм төрд итгэх итгэлийг, иргэдийг улс төрчдөд итгэх итгэлийг, төр, улс төрийн намуудад итгэх итгэлийг ингээд байхгүй болгож байна. Тэгэхээр энэ дээр цаашид та бүхний зүгээс энэ мөрийн хөтөлбөрийн сонгуульд орохын өмнөх биш, энэ дараах үйл явцад нь ямаршуу байдлаар хяналт байвал зохистой гэж бодож байгаа вэ?

Миний бодлоор ядаж энэ сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон ялсан нам жишээлбэл өөрийн мөрийн хөтөлбөрийнхөө гол агуулгуудыг тэр мөрийн хөтөлбөр нь ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт ордог байх ёстой гэсэн ийм бодолтой байгаа юм. Тэгэхээр жишээлбэл сая энэ төсөв хэлэлцэх үед ч гэсэн бүх намууд л улсын төсвийн зарлагыг дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувиас хэтрүүлэхгүй гэдэг шаардлага жишээ нь Монгол ардын нам, Ардчилсан нам төсвийн зарлагыг 20 хувиар буулгана, ХҮН нам төсвийн зарлагыг бууруулна гэсэн мөртөө бүгдээрээ нийлээд ороод ирэхээрээ энэ заалтаа жишээлбэл ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр дээрээ оруулахгүй, чиглэл, оруулж ирж байгаа төслүүд нь тэрнийхээ эсрэг ингээд явж байна. Тэгэхээр энэ дээр ямар ч хариуцлага байхгүй. Өөрөөр хэлбэл тэр ард түмэн засгийн эрхийг барина гэдэг энэ үйл явцаа Улсын Их Хурлын сонгуулиар улс төрийн намуудад ингээд шилжүүлж байгаа, улс төрийн намаас нэр дэвшүүлсэн төлөөлөгчдөөр дамжуулан, Улсын Их Хурлын гишүүдээрээ дамжуулаад ийм хэрэгжүүлэх процесс явж байна. Тэгэхээр яг энэ үйл явцад нь бие даасан улс төрч ч гэдэг юм уу, нэг Улсын Их Хурлын гишүүд байр суурь илэрхийлнэ гэхээсээ илүү улс төрийн намаараа жишээлбэл намын бүлэг нь жишээлбэл ил тод биш ийм бүтцээрээ дамжуулаад жишээлбэл яг намын байр суурь гэдэг байдлаар хангадаг. Тэгэхээр энэ чиглэлээр энэ мөрийн хөтөлбөрөөр хамгийн чухал энэ заалттай холбоотойгоор сонгууль эрх мэдэл авсны дараа ямар зохицуулалтууд байвал зүгээр гэж бодож байгаа вэ? Энэ талаар та бүхний санаа бодлыг сонсьё.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 8 дугаар микрофон Сүнжид дарга хариулт өгье.

Д.Сүнжид: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Сонгуультай холбоотой 92 оноос хойш харахаар 9 удаагийн сонгуульд энэ нөхцөл байдал тухай бүр нь өөрчлөгдсөөр л ирсэн юм байна. 1-д 2, 3 зүйл дээр бид анхаарал хандуулах шаардлагатай хэвээрээ байгаа. 1 дүгээрт сонгогчдын боловсролын асуудал байна. 2 дугаарт энэ намуудын соёл төлөвшил, дотоод зохион байгуулалт, ардчилал гэж нэрлээд байгаа энэ асуудал байна. 3 дахь нь хууль тогтоомж, сонгуулийн яг харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж, үүний тогтвортой байдал гээд 3 асуудал. Намуудын мөрийн хөтөлбөртэй холбоотой шинээр орсон зохицуулалт юу вэ гэхээр Үндэсний аудитын газраас Алсын хараа 2050 гээд энэ бодлогын баримт бичигтэй нийцэж байна уу, үгүй юү гэдгийг шалгасан. Энэтэй холбоотой энэ нь өөрөө чөлөөтэй байх зарчмыг зөрчиж байна гэдэг дүгнэлтийг хийсэн. Яг таны асуусан мөрийн хөтөлбөрийг мөрийн хөтөлбөрөө намууд тухай бүр өөрийн онцлогтойгоор дэвшүүлээ зүүний, барууны үзэл баримтлалдаа

тулгуурлаад. Тэгээд сонгогчдын саналыг авлаа, олонх боллоо. Тэгвэл энэ нь өөрөө тухайн засгийн төрийн эрх барих байгууллагын бодлогод байж байх ёстой юу гэдэг нэг асуудал байна. Энэ дээр тухайлан энэ илтгэл дээр бид дүгнээгүй.

Харин илүү юун дээр дүгнэсэн юм бэ гэхээр энэ араас нь хариуцлага тооцох асуудал үнэхээр сул юм байна лээ. Нэр дэвшигчдийн хувьд ч асуудал байна. Бид юу гэж хэлдэг вэ гэхээр эргээд дүн тавина, сонгогчид дүн тавина гэдэг ийм үндэслэлээр бид энийг орхиод байгаа дүр зурагтай юм байна. Зардлын асуудал байна, тайлагналтын асуудал байна. Тэгээд энэ асуудал дээр бид цаашдаа энэ бүтэн цикл гэж үзэж энэ сонгуулийн харилцааг зохицуулах ёстой гэдэг таны саналыг дэмжиж байна.

Д.Амарбаясгалан: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт асууж, үг хэлье.

М.Нарантуяа-Нара: Сайн байцгаана уу, та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. ХЭҮК-оос гаргасан Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл 6 бүлэг зүйлд энэ 470 хуудас хүний эрхийн зөрчил, энэ дотор хуудас нэг бүр дээр хүний эрхийн зөрчлийн статистик тоо, судалгаа бүх юмнууд байж байгаа юм. Тэгээд ийм чухал юм хэлэлцэж байгаа энэ үеэр ер нь ихэвчлэн хүний эрхийн зөрчил, хүний эрхийн зөрчлөөс үүдэлтэй энэ бүх асуудлууд сонгуулийн үеэр энэ улс төрийн намуудын сонгуулийн шоу PR болдог. Ялангуяа энэ АН сонгууль болохоор энэ бүх үзэгдлүүдийн эсрэг маш сайн дуу хоолой болж ард түмний итгэл найдварыг авч гарч ирчхээд, өнөөдөр яг энэ чухал асуудлыг хэлэлцэж байгаа үед ингээд нэр төр, яасан ийсэн юу гээд ингээд байхгүй байгаа нь үнэхээрийн энэ зүгээр харамсах ёстой, харамсаад өнгөрөх зүйл биш. Иргэд, олон нийт ч гэсэн өөрсдийнхөө итгэл хүлээлгэж сонгосон энэ Улсын Их Хурлын гишүүд, энэ өөрсдийнхөө дэмжсэн энэ нам, улс төрийн эвслээсээ тэгш жигд хариуцлага нэхдэг байгаасай гэж би бодсондоо энийг хэлж байгаа юм.

Би өнөөдөр, өнөөдрийн хурлаар маш олон ялангуяа энд онцолсон хүний эрхийн асуудал дундаа хүүхдийн эрхийн асуудал, тэр дундаа 18 асуудлыг багтааж хэлэлцүүлж байсан бол энэ удаад хүүхдийн бэлгийн хүчирхийллийг онцолж оруулж ирсэн нь энэ учиртай. Жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа энэ асуудлыг өнөөдөр бид учир шалтгаан, нөхцөл байдлыг нь тодруулаад ингэж хэлэлцэж явахгүйгээр зөвхөн дүн үзүүлэлтийг нь бид яриад цаашдаа ямар ч ахиц дэвшилгүй байх юм байна гэсэн баталгаа нь энд байгаа үзүүлэлтүүд байна гэж би хувьдаа харж байгаа юм. Зөвхөн сүүлийн 5 жилд 0-7 насны, 7 нас гэдэг чинь 2 дугаар ангийн хүүхэд гэсэн үг шүү дээ. 0-7 насны 110 хүүхэд бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон байгаа. 110 хүүхэд энэ танхим дотор оруулаад ирээд энэ бүх танхим дотор байгаа сандал дээр суулгавал энэ танхим дүүрнэ гээд бод доо.

Энэ хүүхдүүдийн асуудал АН-ын асуудал биш юм уу. Яагаад сонгууль болохоор бүх нийтийн зовлон зүдгүүр, бэрхшээл, асуудал бэрхшээлийг шоудаж, PR-даж та нарын тэрийг бид хамгаална гэж санал авч гарч ирдэг байж өнөөдөр болохоор нэг намын гишүүдийнхээ нэр хүнд, яасан ийсэн юу гээд. Их Хурал явдгаараа явж байна, ажил нь явдгаараа явж байна. Хэлэлцэх асуудал нь ар араасаа шил шилээ дагачихсан байж байна. Үгүй ээ тэгээд өнөөдөр иргэдийнхээ асуудлыг шийдэхгүйгээр, хэлэлцэхгүйгээр ар араасаа ингээд хүлээж байгаа

ажлуудыг ингээд давхардуулаад, давхардуулаад, ингээд бөөгнөрүүлээд орхиод байх юм бол энэ Их Хурал чинь харин цаашдаа юу болох юм бэ?

Дээрээс нь би энэ үзүүлэлт, энэ судалгаанууд дээр энэ ХЭҮК харьцангуй сайн юм гаргаж ирж байгаа ч гэсэн энэ жишээлбэл хамтарсан багийн энэ нөгөө 31820 тохиолдолд ажилласан ч, төрөл зүйлээр нь ангилаагүй энэ юун дээр маш том учир дутагдалтай зүйл гэж харж байгаа юм. Бид нар энэ хүүхдээ хүчирхийлээд байгаа хүмүүс яг ямар төрлийн хүмүүс байгаад байгаа юм бэ, үнэхээр цус ойртчихсон хүмүүс нь хүүхдүүдээ, үр ач, ураг төлөө хүчиндээд ингээд байгаад байгаа юм уу, эсхүл хойд эцгүүд байгаад байгаа юм уу, эсхүл ах дүү, хамаатан садан гээд байдаг. Энэ юунаас болоод байгаа юм шалтгаан нөхцөлийг нь бид тодруулж мэдэхгүйгээр, мөн түүнчлэн энэ үйлдэгдээд байгаа хэсгүүд нь хаана байгаад байгаа юм, алслагдсан газруудад байгаад байгаа юм уу, нийслэлд байгаад байгаа юм уу, эсхүл газар зүйн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нарантуяа-Нара гишүүний 1 минут нэмж өгье.

М.Нарантуяа-Нара: Гэх мэтчилэн бид энэ бүх гэмт хэргүүд үйлдэгдээд байгаа газар, нөхцөл байдал энэ бүх юмыг тодруулж юу яахгүйгээр бид яаж энийг тэмцэхээ мэдэхгүй байна. Магадгүй ингээд байнгын төсөв мөнгө гээд л хэлээд байдаг. Тэгвэл төсөв мөнгийг нь жилээс жилд нэмж байгаа. Гэтэл тэрэнтэй уралдаад төсөвтэй нь уралдаад жилээс жилд гэмт хэргийн үзүүлэлт нэмэгдээд байна гэдэг энэ бол учир нь, асуудал нь мөнгөн дүндээ байгаа биш юм байна гэдгийн илрэл. Тэгээд би энэ дээр Хууль зүй, дотоод хэргийн яам болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ажлууд төдийлөн байгаа онож, үр дүнтэй ажиллаж чадахгүй байна уу гэж харж байна. Тийм ч учраас өнөөдөр хамтарсан баг нь асуудлаа бүрэн илрүүлж чадахгүй, урьдчилан сэргийлж чадахгүй, учирсан хохирлыг барагдуулах ажлыг хийж чадахгүй, төрөл зүйлээр нь ялгаж салгаж чадахгүй байна гэдэг чинь энэ Улсын Их Хурлаас батлаад байгаа энэ жишээлбэл энэ жилийн хувьд гэхэд 21 тэрбум орчим төгрөг, энэ их мөнгө төгрөг энэ татварын мөнгө.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Энхтайвангийн Бат-Амгалан гишүүн алга байна. Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Мөнхсоёл: Сайн байцгаана уу, оройн мэнд. Тэгээд энэ маш чухал асуудал, тэгээд удаа дараа хэлэлцэгдэж байна. Талархаж байна. Миний бодлоор хүний эрх гэдэг маш өргөн хүрээтэй, маш олон талыг хамруулсан, олон хүчин зүйл шалтгаант ийм гүн гүнзгий асуудал. Тэгээд нөгөө талдаа хүн бүрд хамаатай. Хүн бүр гэдэг нь үр хүүхдүүдэд маань ч хамаатай. Өмнөх гишүүд хэллээ. Булгантуяа гишүүн гэр бүлийн доторх хүчирхийллийн асуудлыг ч хөндлөө. Нарантуяа гишүүн маань ингээд сая хэлж байна. Мөнхтуяа гишүүн маань хүүхдийн эрхийн асуудал гээд. Тэгэхээр энэ тайлан дээр гүнзгийрүүлж харж, анализ хийх ёстой нэг асуудал нь миний бодлоор орлогын ялгаа хэрхэн нөлөөлж байна, тэгээд газар зүйн байршил хөдөө, хотын ялгаа хэрхэн нөлөөлж байна гэдгийг гүнзгий харах хэрэгтэй юм шиг санагдсан. Яагаад гэвэл өмнөх гишүүний хэлсэн яг тэр шалтгаан, учир үндэслэлийг нь олж харахгүйгээр шийдэхэд хэцүү гэдэг нь үнэн л дээ.

Энэ Монгол Улсад хүний эрх хангалтгүй байгаа, хангаж чадахгүй байгаа гэдгийг манай энэ ХЭҮК хэлснээс гадна энэ тайлангаас харж болохоос гадна, олон

улсын түвшинд маш олон зэрэглэл индексүүд байдаг. Би заримаас нь товч дурдахад Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индексээр жишээлбэл Монгол Улс 180 орноос 109 эрэмбэлэгдчихсэн буюу 21 оноос даруй нэлээн олон байраар ухарчихсан, 21 онд болохоор бид Монгол Улс 68 дугаар байранд орж байсан. Мөн 2 дугаарт нь Дэлхийн шударга ёсны төслөөс гаргадаг ийм индекс байдаг. Тэн дээр Монгол Улс 142 улсаас 69 дүгээр байранд орчихсон байгаа. Энд тухайн улсын ЗГ-ын ил тод байдал, Авлигын төсөөллийн индекс, хүний эрх чөлөөний индекс гээд олон төрлийн 8 төрлийн шалгуур үзүүлэлтийг үндэслэж гаргадаг. 3 дугаарт нэг дурдмаар байгаа нэг чухал индекс бол жендерийн тэгш бус байдлын индексээр Монгол Улс 146 орноос 85-д жагссан 24 оны байдлаар. Энэ мэтчилэн маш олон индексүүдийг дурдаад байвал Монгол Улс бусад улсуудтай харьцуулж зэрэгцүүлэхэд хангалтгүй дүн аваад байгаа юм. Тэгээд энэ тайланд ч гэсэн зөндөө олон статистик тоо харж болно.

Би тухайлбал, бид удахгүй Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хуулийн төслийг авч хэлэлцэнэ. Нөгөө талдаа маргааш тухайлбал миний хувьд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний ийм форум хэлэлцүүлэгт НҮБ-ын байран дээр сэтгүүлчидтэй, бусад иргэний нийгмийнхэнтэй хамтраад панелистаар орох гэж байгаа ийм хүн байгаа юм. Хүний эрхийн Комиссоос Нарантуяа орно. Тэгэхээр энэ дээр би холбогдуулаад бүүр тодорхой хариулт авмаар байгаа юм. Жишээлбэл Монгол Улсад энэ үндэсний, яг нэг манай энэ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гаргасан энэ тайлангийн 135 дугаар хуудсанд байгаа байхгүй юу. Монгол Улсад нэр бүхий сэтгүүлчдийг баривчилж, цагдан хорьж, хорих ялаар шийтгэж буй явдал нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан болон иргэний нийгмийн идэвхтнүүд ямарваа шийтгэл хүлээхээс айж эмээх зүйлгүйгээр үйл ажиллагаагаа олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн чөлөөтэй үйл ажиллагаа явуулах нөхцөлийг нэн даруй хангах шаардлагатай байгааг Хил хязгааргүй сэтгүүлчид болон Олон улсын сэтгүүлчдийн холбоо зэрэг олон байгууллагууд сануулж, шаардсан. Энэ өмнө нь зөвхөн 23 оноос өмнө гарсан ийм шаардлага шүү дээ.

Мөн нэмж хэлэхэд маш олон ийм иргэдийн нэрийг бичсэн байна. Халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн, иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хөндөж, Монгол Улсын иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрмэлзэл зоригийг мохоох үр дагаварт хүрсэн гээд. Энэ жишээ тоо баримтаас гадна ийм кейсүүд байна, 1 минутаа нэмж авъя. Баярлалаа. Тэгэхээр эдгээртэй холбогдуулаад манай Үндэсний комиссынхон ямар шийдэл санал болгож амьдралд хэрэгжүүлж ирэв? Одоо мэдээж байдал төгс шийдэгдээгүй, энэ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хууль яригдаж байна. Цаашдаа юунд анхаарах вэ гэдэг дээр өөрсдийнхөө санал, бодол, зөвлөмжийг хуваалцаач гэж асуумаар байна?

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

С.Дондов: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Энэ бид энэ дүгнэлтийг гаргахдаа хэвлэл мэдээллийн ажилтнууд ямар журмаар цагдан хоригдох, хорих ял оногдуулах, оногдуулсан энэ кейсүүд дээр тодорхой ажилласан, гомдол мэдээллийн мөрөөр ХЭҮК-оос дүгнэлт гаргасан. Ийм учраас хэвлэл мэдээллийн ажилтнуудын сэтгүүлчдийн үзэл бодлоо илэрхийлэх, олон нийтийн мэдэх эрх тодорхой хэмжээгээр хязгаарлагдаад байна. Тийм учраас энийг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг тун яаралтай баталж гаргах

хэрэгтэй. Гэхдээ батлахын өмнө зайлшгүй сэтгүүлчдийн өөрсдийнх нь амьдрал, үйл ажиллагаагаа явуулахад нь ямар нөхцөл байдалд байгаа гэдгийг сайтар судалж, тэдний бодит нөхцөл байдал, цаашид үйл ажиллагаагаа явуулахад нь таарсан ийм хуулийг бий болгох хэрэгтэй. Энэ зөвхөн хэвлэл мэдээллийн эрх чөлөөний төлөө ажилладаг сэтгүүлчдийн тухай хууль биш. Энэ бол олон нийтийн мэдэх эрхийг баталгаажуулсан ийм чухал хууль учраас олон нийтийн болон бусад иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, энэ чиглэлээр ажилладаг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг иргэдийн хүсэл эрмэлзлийг багтаасан ийм чухал хууль байх ёстой. Энийг баталснаар хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай индекс тодорхой хэмжээгээр дээшилж болох нэг үндэслэл бий гэж үзэж байна.

Энэ дээрх олон нэр дурдсан энэ хүмүүсийн кейсийг манай ХЭҮК-оос гаргасан дүгнэлтүүдийг гаргасан учраас энэ кейсүүдийг оруулсан байгаа. Үүнд тодорхой хэмжээгээр хоригдоод гараад ирчихсэн байгаа сэтгүүлчдэд бид дүгнэлт гаргасан. Мөн сүүлд нь Ноорог.мн мөн ажиллаж байгаа залуусын талаар үйлдэгдсэн асуудлын талаар тодорхой дүгнэлт гаргасан. Одоо мөн Цагдаагийн ерөнхий газраас тодорхой авч хэрэглэж байсан, энэ үйл ажиллагаа явуулж байсан энэ техник хэрэгсэл, бусад материалуудыг, баримтуудыг нь буцааж өгөх асуудал дээрээ бид тусгайлан анхаарч, холбогдон ажиллаж байна.

Цаашид бидний тавьсан хүний эрх хамгаалагчийн гол бүрэлдэхүүн хэсэг болох энэ сэтгүүлч, өмгөөлөгчдийн талаар тодорхой 7 саналыг Улсын Их Хуралд бодлогод нэмэр болох байх гэсэн агуулгаар оруулсан байгаа. Үндсэндээ нийтдээ 16 саналыг бодит амьдралын явцад хэрэгжээд явах ийм чухал санал гэж энэ тус бүлэгт оруулсан байгаа.

Д.Амарбаясгалан: Баатаржавын Мөнхсоёл гишүүнд 1 минут нэмж өгье, тодруулж асууна.

Б.Мөнхсоёл: Баярлалаа. Тэгээд 1 юмыг нэмж хэлэх гэсэн юм. Хамгийн гол нь тухайн нийгэмд сенсац юм уу, кейс юм уу, тохиолдол гарлаа гэхэд үндэсний комисс маань Хүний эрхийн Үндэсний Комисс маань ажилладаг юм шиг байгаа юм. Шийдвэр гардаг. Тэгэхдээ нийгэм болохоор ямар шийдэл гарсан юм, яаж дүгнэсэн юм гэдэг мэдээлэл авдаггүй шүү. Гэтэл тохиолдол гарсан нь бол бүүр ингээд түгж, маш сайн тархдаг. Тэгэхээр энэ хариу гаргасан шийдэл, шийдвэр, саналаа ил тавьж байх хэрэгтэй юм болов уу гэж боддог.

2 дугаарт нь зарим нэг кейс бол бүр шийдэлгүй ингээд хаягдаад орхигддог. Өмнө нь би ч гэсэн намар өртсөн. Сүнжид даргатай холбогдсон. Цагдаад тухайн өөр гишүүн бид хоёрын өмнөөс гомдол гаргасан гэж байгаа, хариу одоо хүртэл хэлээгүй. Тэгэхээр хариу үйлдэл маш чухал бөгөөд цаг хожих бол амьдралд маш чухал байдаг шүү. Тэгэхээр энэ механизм дээрээ сайн ажиллаарай. Хүний эрхийг хурдан шуурхай хангах механизм маш чухал шүү. Бодит байдалд энийг яриа болгоод.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Өнөөдөр Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг Улсын Их Хурал хэлэлцэж байгаа. Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж байгаа 2 дахь илтгэл. Үүнтэй холбогдуулаад Хүний эрхийн комиссоос Монгол Улсын Их Хурлаар шийдвэр гаргуулахаар 6 бүлэг саналыг ирүүлсэн

байгаа. Сонгогдох, сонгох, сонгогдох эрхийн талаарх, хүний эрх хамгаалагчийг хамгаалах талаар, Хүний эрх ба цахим технологийн талаар, цахим орчинд үйлдэгдэж байгаа жендерт суурилсан хүчирхийллээс хамгаалах талаар, бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийг хамгаалах талаар, шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилтийн талаар гээд бүлэг саналуудыг ирүүлсэн.

Энэ дээр Улсын Их Хурлын гишүүд санал гаргалаа, Улсын Их Хурлын дэд дарга Булгантуяа санал гаргаж хэллээ. Тэгэхээр Улсын Их Хурлын тухай хуулийн 22.3.5, 22.3.6-г үндэслээд уг саналуудыг мэргэжлийн Байнгын хороодоор хэлэлцүүлж, албан ёсоор тогтоол гаргаж, төрийн байгууллагуудад үүрэг чиглэл өгөх үүргийг өнөөдөр Улсын Их Хурлын даргын хувьд өгч байна.

Сонгох, сонгогдох эрхийн талаар Төрийн байгуулалтын байнгын хороо, Хүний эрх хамгаалагчийг хамгаалах талаар Хууль зүйн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо, Хүний эрх ба цахим технологийн талаар Инновац, цахим бодлогын байнгын хороо, Цахим орчинд үйлдэгдэж байгаа жендерт суурилсан хүчирхийллээс хамгаалах тухай Нийгмийн бодлогын байнгын хороо, Инновац, цахим бодлогын байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо, Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүдийн эрхийг хамгаалах талаар Хууль зүйн байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороо, Шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилтийг хангах талаар Хууль зүйн байнгын хороо хариуцаж уг асуудлыг нэг бүрчлэн ярилцаж, холбогдох тогтоол, шийдвэрийг гаргах үүрэг чиглэлийг өгч байна. Эдгээр Байнгын хороодоор хэлэлцсэн асуудлыг Хууль зүйн байнгын хороо мэргэжлийн Байнгын хорооны хувьд нэгтгэж, Улсын Их Хуралд танилцуулж, хэлэлцүүлэх үүргийг өглөө.

Нэгдсэн хуралдаанаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг хэлэлцлээ.

16.23 цаг

Бусад асуудлаас Ардчилсан намын бүлэг нэг өдрийн завсарлага авсан тул өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. Хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА